

Гүнзгий мэд


MONGOLIAN ECONOMY

2016 ОНЫ 01 САР №01 (103)

Mongolianeconomy.mn

МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ
25
1991-2016 ЖИЛ

Хөрөнгийн зах зээл
хөгжлийн хөшүүрэг



ДЭЛХИЙН ХӨТӨЧ Бүтэн жилийн турш таны ширээн дээр



“Mongolian Economy” сэтгүүл “The Economist” сэтгүүлийн жилийн
“The World in 2016” дугаарыг тусгай зөвшөөрлийн хүрээнд монгол хэлээр гаргаад байна.

Дэлхий 2016: Энэ оныг гурван үгээр дүгнэж болох.

ЗОВЛОН ЗҮДГҮҮР, ЭМЭГТЭЙЧҮҮД болон ЯЛАЛТ.

Энэ удаагийн дугаарт Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Моди зэрэг нөлөө бүхий улстөрчдөөс гадна тусгай бүлэгт Канадийн зохиолч, Америкийн чиг хандлага ажиглагч, Израилийн шинэлэг загвар зохион бүтээгч болон Австралийн алдартай зурхайч гэх мэтийн хүмүүс хувь нэмрээ оруулжээ. Тус сэтгүүлд дэвшүүлэн тавьсан таамаг төлөвийн 90 хувь нь биелдгээрээ давуу талтай гэдгийг уг сэтгүүлийн эрхлэгч Даниел Франклин онцлон тэмдэглэсэн. Тийм учраас сэтгүүлийн байнгын уншигчид жил бүр эргэн ирдэг.

Бид Монголын уншигчдыг ч энэ эгнээнд элсүүлж чадсандаа баяртай байна. Та бүхэн таалан уншина уу.

Үнэ: 40.000₮

Утас: 7011 5477, 7011 5476, 88006228, 94092904



Зөвхөн төрийн өмчит гэлтгүй нээлттэй компани болж бизнесээ өргөжүүлбэ гэж санал ирүүлж, сонирхож байгаа олон хувийн компани байна, хуудас 5



ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ ЭРХЛЭГЧ:

Д.Бэжбаяр

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ,
ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

О.Түвшин

СЭТГҮҮЛЧИД:

Б.Үүрийнтуяа

Б.Энхцэцэг

Г.Орхон

Ц.Элбэгсайхан

ОРЧУУЛАГЧ:

Б.Энхмөнх

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Барянжав

Хаяг: Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, I хороо, Экспресс таур. 1101 тоот

Вэб: www.mongolianeconomy.mn

И-мэйл: info@mongolianeconomy.mn

Утас: 976-7011 5476

Борлуулах цэгүүд:

“Интер ном”

“Цэцэг төв”

“Минж плаза”

“Алтантүлхүүр” номын дэлгүүр

“Номин” супермаркетин бүх салбар

“Макс” супермаркетин бүх салбар

“Фреско” супермаркет

BTSI супермаркет

“Аз орчлон” номын дэлгүүр

“Билэг” их дэлгүүрийн номын тасаг

“Гранд Плаза” дахь супермаркет

“Мир” номын дэлгүүрийн:

“Grand plaza”

“Metro mall”

“Sky” супермаркет

“Улаанбаатар” их дэлгүүр

“Max mall” дахь салбарууд

Санхүүгийн зах зээл

5 М.Болор: Одоо бид улам өөдрөг ирээдүйг бүтээхийн төлөө ажиллах ёстой

Зөвхөн төрийн өмчит гэлтгүй нээлттэй компани болж бизнесээ өргөжүүлбэ гэж санал ирүүлж, сонирхож байгаа олон хувийн компани байна

8 Түүхэн замнал

Монголын хөрөнгийн бирж байгуулагдав

10 Тооны хэлээр

Хөрөнгийн захын 25 жилийн түүхэн статистик

12 Хамгийн хамгийн

Хөрөнгийн захын 25 жил дэх хамгийн өндөр үзүүлэлтүүд

13 2015 оны үнэт цаасны арилжааны мэдээлэл

Өнгөрсөн онд өдөрт дунджаар 2.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 163.9 мянган ширхэг үнэт цаас арилжлаа

17 Хөрөнгө босгогчдод зориулсан мэдээлэл

20 Хөрөнгө оруулагчдад зориулсан мэдээлэл

26 Гишүүнчлэлийн журмын шинэчлэлт

28 Бүртгэлийн журмын шинэчлэлт

30 Хяналт шалгалтын журмын шинэчлэлт

31 “МИК Холдинг” ба IPO

“МИК Холдинг” ХК нь 1.9 их наяд төгрөгийн зээлийн багцыг худалдан авч үнэт цаасжуулсан

32 “Монгол шуудан” ба IPO

Анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2015 оны арванхоёрдугаар сарын 28-наас энэ оны нэгдүгээр сарын 06-ны хооронд явууллаа

33 Т.Гандулам: Бүтээгдэхүүн чухал ч худалдан авагчдыг бэлтгэх хэрэгтэй

Хөрөнгийн бирж өөрийгөө зохицуулах байгууллага болсноор төр, хувийн хэвшлийн зохистой түншлэлийн харилцааг бүрдүүлж өгнө

35 Төрийн өмчийг Хөрөнгийн биржээр дамжуулан хувьчлахын ач холбогдол

Хувьцаа эзэмшигч бүр төрийн өмчит хувьцаат компанид хяналт тавих боломж нээгдэнэ

36 Гацууртын төлөө “гараа өргөө”

Стратегийн ордын 10 хувийг Хөрөнгийн биржээр арилжаалах ёстой

40 Хувьцаат компани болсноор засаглал зөв шугамд орлоо

Бид бусдаас нэг их хол хоцроогүй, хөл нийлүүлж яваа

41 Давааны цаадах даваа

Том шийдвэр дагасан том үр дагавар

43 Томрох хүсэл

Бондыг даатгах болсон нь дотоодын санхүүгийн салбарт шинэ үзэгдэл болж буй

44 Шинэ нөхцөл

Анхдагч зах зээл дээр хувьцаа худалдан авах захиалга нийлүүлэлтээс зуун хувь илүү байлаа



Давааны цаадах даваа

Хямрал зөнгөгчдийн зүгээс Америкийг тийм ч дархлаа сайтай болсон гэж итгэхгүй байна. “Wall Street Journal” сэтгүүлийн санал хураалтад оролцсон 65 эдийн засагчийн ихэнх нь ХНБ ирэх таван жилийн дотор тэг хувийн бодлогын хүү рүү эргээд ухарна гэж үзжээ, хуудас 41



Гацууртын төлөө “гараа өргөө”

Энэ удаад Гацууртын ордын 34 хувийг төр эзэмшиж, түүнийг орлох ашигт малтмалын нөөц ашигласны татварыг гурван хувиар тогтоожээ, хуудас 36



Хувьцаат компани болсноор засаглал зөв шугамд орлоо

Өмнө нь иргэд зөвхөн орон сууцтай болж, МИК-ийн ашиг орлогыг хүртэх боломжгүй байсан бол одоо хувьцаа эзэмшигч болсноор бий болж байгаа нийт баялгаас дивиденд ногдол ашгийг хүртэх боломж бий болгоё гэдэг зорилго тавин ажилласан, хуудас 40



Т.Гандулам: Бүтээгдэхүүн чухал ч худалдан авагчдыг бэлтгэх хэрэгтэй

Хөрөнгийн бирж өөрийгөө зохицуулах байгууллага болсноор төр, хувийн хэвшлийн зохистой түншлэлийн харилцааг бүрдүүлж өгнө, хуудас 33



Томрох хүсэл

Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк зэрэг байгууллагууд зохицуулалтуудын хязгаарыг суллаж, боломжуудыг нээгээд өгөх юм бол асар их чадавхи энэ салбарт байгааг зөвхөн моргейжээр дамжуулан зах зээл хэр хурдацтай өссөнөөс харж болно гэдгийг оролцогчдын зүгээс онцолсон. Олон компани энэ зах зээлийн хүрээнд өсөх, томрох хүсэлтэй байна, хуудас 43

МЭНДЧИЛГЭЭ

Монголын хөрөнгийн бирж байгуулагдаж, Монгол Улсад Хөрөнгийн зах зээл үүсэж хөгжсөний түүхт 25 жилийн ойн баярын мэндийг хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүд, хөрөнгө оруулагч, үнэт цаас гаргагч Та бүхэнд баяр хүргэе.



1991 онд Монгол Улсын Засгийн газраас улсын өмч хувьчлалын ажлыг эхлүүлэх, Үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх зорилгоор анх Монголын хөрөнгийн биржийг байгуулж, 1995 оноос бэлэн мөнгөний арилжаа буюу Үнэт цаасны хоёрдогч зах зээлийг эхлүүлж байсан түүхтэй.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын засгийн газраас хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж, эрчимжүүлэх бодлогыг баримталж, хууль эрх зүйн орчныг сайжруулж, олон улсын жишигт хүрсэн дэд бүтцийг бий болгосноор Монголын санхүүгийн зах зээл өсөж 21.5 их наяд төгрөгт хүрлээ.

2014 онд Монгол Засгийн газрын шийдвэрээр Сангийн яам Монголын хөрөнгийн биржийн хувьцаа эзэшигч болж, 2015 онд 546 тэрбум төгрөгийн арилжааг хийснээр 25 жилийн түүхэн дээд амжилтыг тогтоолоо.

Монгол Улсын эдийн засгийн хурдацтай өсөлт, хөгжил, Санхүүгийн зах зээлийн өсөлтөд Хөрөнгийн зах зээл тэр дундаа Монголын хөрөнгийн биржийн үүрэг өндөр байна гэдэгт итгэж байна.

Та бүхэнд эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

САНГИЙН САЙД
Б.БОЛОР

Ярилцлага

М.Болор: Одоо бид улам өөдрөг ирээдүйг бүтээхийн төлөө ажиллах ёстой

Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал М.Болортой ярилцлаа.

-Сүүлийн саруудад Монголын хөрөнгийн бирж сонин ихтэй байлаа. Хоёр ч томоохон IPO хийгдлээ. Энэ сэдвээс яриагаа эхлэх үү?

Юуны өмнө Монголын хөрөнгийн биржийн 25 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан энэ хугацаанд хөрөнгийн зах зээлийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсаар ирсэн нийт хувьцаагт компани, үнэт цаасны компани, андеррайтер болон хөрөнгө оруулагч, түншүүддээ 25 жилийн ойн баярын мэндийг дэвшүүлье. Биржийн бүхий л ололт амжилт, өнөөдрийн байр суурь та бүхний хүчин чармайлт, хүч хөдөлмөрөөр бий болсон. Мөн биржийн үе үеийн удирдлага, баг хамт олны хичээл зүтгэл, хувь нэмэр ч их бий.

Нэг л өдөр хөрөнгийн захыг хөгжүүлчихдэггүй. 1991 оны нэгдүгээр сарын 18-нд байгуулагдсан Монголын хөрөнгийн бирж маань өнгөрсөн хугацаанд амжилт бүтээл, алдаа оноотой өөрийн гэсэн түүхийг бүтээж, арвин баялаг туршлага хуримтлуулжээ. Харин одоо бид улам өөдрөг ирээдүйг бүтээхийн төлөө ажиллах ёстой.

-“Мик холдинг” ХК нэг сарын дотор 37 тэрбумын хөрөнгийг босгосон. Араас нь “Монгол шуудан” компанийн 34 хувийг хувьчиллаа. Дотоодын хөрөнгийн заххаас мөнгө босгох боломжтой гаргадлаа. Эндээс та ямар дүгнэлт хийх вэ?

Энэ хоёр IPO бол бидний ажлын эхлэл. “МИК Холдинг” ХК биржээр дамжуулан 37 тэрбум төгрөгийн хөрөнгө босгосон нь манай биржийн түүхэн дэх хамгийн өндөр дүнтэй IPO боллоо. Мөн “Монгол шуудан” ТӨХК 6.3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэх санал ирүүлсэн ч 12.6 тэрбум буюу хоёр дахин их захиалга ирлээ.Өөрөөр хэлбэл, хөрөнгийн зах зээлээс хямд эх үүсвэртэй хөрөнгө татах бололцоо байна гэдгийг харуулж чадлаа. Энэ нь хөрөнгийн зах зээл сэргэж, цаашдаа хөгжих боломж байгааг харуулаад зогсохгүй эдийн засгийн нөхцөл байдал амаргүй байгаа ч



ФОТОГ Б.БЯМБА-ОЧИР

дотоодын хөрөнгө оруулагчид идэвхтэй, хөрөнгө оруулалт хийх сонирхолтой байгааг илтгэж байна. Нэг үгээр хэлбэл, хөрөнгийн зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлж, хүлээлт маш өндөр байгааг харууллаа. Иймд цаашид бид илүү олон бүтээгдэхүүн гаргаж, зах зээлийг улам идэвхжүүлэх чиглэлээр ажиллаж байна.

-“Монгол шуудан”ХК-ийн хувьцааг арилжаалахдаа бага хувьцаа авах саналыг ирүүлсэн иргэдийн захиалгыг хамгийн түрүүнд 100 хувь бүртгэсэн. Өмнө нь яагаад ийм зохицуулалт хийдэггүй байсан юм бэ?

Монголын хөрөнгийн биржээр анх удаа төрийн өмчит компанийн IPO хийсэн. Анхдагч арилжааг явуулахдаа тоо хэмжээ зааж, үүнээс доош санал ирүүлсэн хувьцааны захиалгыг 100 хувь хүлээн авна гэсэн зохицуулалт оруулсан. Өөрөөр хэлбэл, “Монгол шуудан” компанийн хувьд 10 000 ширхэгээс доош хувьцаа худалдаж авна гэсэн саналыг хамгийн түрүүнд биелүүлсэн. Нэг ширхэг хувьцааг худалдаж авах санал орж ирсэн тохиолдол ч бий. Ингэснээр олон нийтэд нээлттэйгээр, хүртээмжтэйгээр хуваарилсан гэсэн үг. Харин 10 000 ширхэг хувьцаанаас дээш санал тавьсан хөрөнгө оруулагч нарт үлдэгдэл хувьцааг

хувь тэнцүүлэн хуваарилсан.

Яагаад өмнө нь ийм зарчим барьдаггүй байсан юм бэ гэж та сонирхож байна. IPO хийх зорилго нь янз бүр байдаг. Төр засгаас “Монгол шуудан” төрийн өмчит компанийн хувьцааг иргэд, хөрөнгө оруулагч нарт тэгш эрхтэйгээр хуваарилъя гэсэн бодлого барьсан хэрэг. Тухайлбал, “Монгол шуудан” ХК-ийн олон нийтэд санал болгох хувьцааны нэгж үнийг 185 төгрөг байхаар тогтоосон. Тэгвэл хувийн компани IPO хийе гэвэл тэдээс эхэлж худалдаална гэж санал өгөх боломж бий. Бас зөвхөн цөөн тооны том хөрөнгө оруулагчийг татаж хөрөнгө босгоё гэж зорилтоо тодорхойлж ч болно. Бирж болон үнэт цаасны компани, андеррайтеруудын хувьд хөрөнгө босгогч, хөрөнгө оруулагч нартаа төрөл бүрийн боломжуудыг олгож, уян хатан санхүүгийн хэрэгсэл бий болгох талаас нь ажиллаж байна.

-Ерөнхий сайд Ч.Сайханбилэг “Монгол шуудан”-гийн хувьчлалын үеэр цан цохиж хэлэхдээ энэ бол эхлэл, цаана нь арваад төрийн компани байгаа гэж хэлсэн. Цаашид ямар компанийн хувьчлалыг Хөрөнгийн биржээр дамжуулж хийх вэ?

Төрийн өмчит компаниудын

**Зөвхөн төрийн өмчит
гэлтгүй нээлттэй компани
болж бизнесээ өргөжүүлье
гэж санал ирүүлж,
сонирхож байгаа олон
хувийн компани байна**



хувьд цахилгаан станциуд болон хоёр уурхайд IPO хийхээр төлөвлөж байгаа. Хэрэв төрийн өмчит компанийн хувьчлал Хөрөнгийн биржээс гадуур явбал тухайн компани нэг, хоёр цөөн тооны хүн эзэмшиж, төвлөрөл үүсдэг. Өмч хувьчлалыг хөрөнгийн биржээр дамжуулан явуулснаар хөрөнгийн зах зээлд олон улсын жишигт нийцсэн хувьцаат компаниуд бий болж, хөрөнгийн захад итгэх итгэл нэмэгдэж, мөн өмч хувьчлалын үйл явц ил тод, шударга, хэрэгжиж бодит үнэлгээндээ хүрч үнэ цэнэ өсөх зэрэг давуу талтайгаас гадна иргэдэд хөрөнгө оруулж өгөөж хүртэх боломжийг нээж өгч байгаа юм. Тухайн төрийн өмчит компанийн хувьд ч гэсэн засаглал нь илүү оновчтой болж, санхүүгийн гүйцэтгэл сайжрах гэх мэт зэрэг нөлөөтэй.

Зөвхөн төрийн өмчит компани гэлтгүй нээлттэй компани болж бизнесээ өргөжүүлье гэж санал ирүүлж, сонирхож байгаа олон хувийн компани байна. Хөрөнгийн зах зээлээс хөрөнгө татаж, нээлттэй компани болоход олон сайн тал бий. Хямд эх үүсвэрээр хөрөнгө татна, байнгын хэрэглэгчтэй болно гээд л.

Олон хувьцаа эзэмшигчтэй болох тусам үнэнч, баталгаатай, найдвартай, байнгын хэрэглэгчтэй болдог. Хувьцааг худалдаж авсан хүн аль болох тухайн компанийнхаа үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан авч хэрэглэхийг бодно. Гэр бүлээ, цаашлаад ах дүү, хамаатан садан, найз нөхдөө ч бүтээгдэхүүнийг хэрэглэхийг уриалан, эгнээндээ нэгтэнэ. Энэ хэрээр тухайн компанийн борлуулалт өсч, ашиг нэмэгдэнэ шүү дээ.

-Одоогоор танайд IPO хийе гэж санал тавьсан хувийн компаниуд байна уу?

Байлгүй яахав. Бидэнд хандсан, зөвлөгөө авсан арваад хувийн компани байна. Түүнээс гадна Үнэт цаасны компаниудад сонирхлоо илэрхийлж, санал ирүүлсээр байгаа. Гэхдээ нээлттэй компани болъё гэсэн болгоныг хүлээн авч IPO хийж болохгүй. Маш тодорхой шаардлага тавигддаг. Өнөөдөр байгуулагдаад маргааш нь нээлттэй компани болъё гэвэл хөрөнгө оруулагч ойлгох ч үгүй, хөрөнгө босгож чадахгүй. Тодорхой хэмжээнд

амжилт үзүүлсэн, байгууллагын соёлтой, түүнээс гадна хэрэгтэй, ашигтай, зөв төсөл хэрэгжүүлж байгаа байгууллагыг л хөрөнгө оруулагч сонирхоно. Нөгөө талаараа эрсдэлтэй компани ороод ирвэл хөрөнгө оруулагчид хохирох болно. Бирж бол тэднийхээ эрх ашгийг хамгаалах ёстой байгууллага учраас эдийн засаг, эрсдэл, засаглал, зах зээлийн үнэлгээ гээд олон талаас нь хянаж, үнэлээд тооцоолоод шийдэлд хүрнэ. Энэ нь үнэндээ санал, баримт материалаа ирүүлсэн компаниудад ч хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, танайх болохгүй байна гээд зүгээр явуулчих биш, ийм ийм зүйл дээр анхаарах шаардлагатай гээд боломж, гарцын хамтын шийдэлд хүрдэг.

-Ашигтай бизнес гэхээр бүгдээрээ шуураад орчихдог. Үүнээс болоод чанартай, чанаргүй бүтээгдэхүүн үйлдвэрлэл хэгийг илүүдэл үүсч, борлуулалтгүй болдог талтай. Барилгын салбар л гэхэд нэг жишээ нь, нэг хэсэг бүгд л барилгачин болцгоосон. Хөрөнгийн зах зээл энэхүү давхардлыг ▶



► **арилгахад ашиг тустай санагддаг.**

Ашигтай, идэвхтэй байгаа зах зээл рүү шурах нь буруу биш, учир нь хэн ч хөрөнгөө өсгөхийг л бодно. Гэхдээ хөрөнгө оруулах арга замд учир бий. Таны хэлдгээр нэг хэсэг барилгын салбар өсөлттэй байна гээд бүгд машин техник худалдаж аваад барилгачин болж байв. Гэтэл салбарын өсөлт саармагжаад ирэх үед хөрөнгөө суллаж чадахгүй болсноор алдагдал хүлээсэн компани олон бий. Аливаа бизнес эрхлэхэд туршлага, бааз суурь, боловсон хүчин, тоног төхөөрөмжийн хүчин чадал зэрэг олон тулгуур шаардагддаг. Тэгвэл тухайн салбарын туршлагатай, хүчин чадал, менежмент сайтай, нэр хүндтэй компанид хөрөнгийн зах зээлээр дамжуулан хөрөнгө оруулалт хийснээр тухайн салбарын өсөлтөөс харьцангуй эрсдэл багатайгаар ашиг хүртэх бүрэн боломжтой. Өөрөө хийснээс ялгаагүй гэсэн үг. Гэтэл бид өнөөг хүртэл өөрсдөө л хийх гэж зүтгэлээ шүү дээ.

Хөрөнгийн зах зээл нь хөрөнгө

оруулагчид хүссэн үедээ оролцож, хүссэн үедээ гарч явах боломжийг олгодог нээлттэй, ил тод байдгаараа ялгардаг. Тийм ч учраас хөрөнгө оруулагчид зах зээлийн нөхцөл байдлаас хамаараад үнэт цаас худалдаж авдаг, хангалттай ашиг хүртлээ гэсэн үедээ гараад явдаг. Өнөөдөр барилгын бизнест ороод, долоо хоногийн дараа уул уурхай ч юмуу өөр нэгэн эрэлттэй бизнес эрхлэх боломж амьдрал дээр тэр бүр олдохгүй. Тэгвэл энэхүү боломжийг зөвхөн хөрөнгийн зах зээл л олгоно.

Сүүлийн үед бизнесмэнүүдийн хандлага их өөрчлөгдөж байна. Зөвхөн бид л эзэн байна гэхээсээ илүү хөрөнгийн зах зээлийг ашиглаж хамтаараа бизнес хийвэл илүү үр дүн, амжилтад хүрэхийг ойлгодог болж байгаа нь ажиглагдаж байна. 25 жилийн хугацаанд алдаж, онож, хангалттай бизнесийн туршлага хуримтлууллаа шүү дээ. Тиймээс хөрөнгийн зах зээлийн цаашдын ирээдүйн талаар их өөдрөг төсөөлөлтэй байгаа.

-Монголын санхүүгийн зах зээлийн үндсэн бэрхшээлүүдийн нэг нь зээлийн хүүний асуудал байдаг. Хүүг бууруулах боломж бий юу?

Өнөөг хүртэл Монголын санхүүгийн зах зээлийн дийлэнх хэсэг хаалттай зах зээлийн зарчмаар явж ирсэн. Хаалттай зах зээл бол хоёр субъектын харилцаан дээр л тогтдог. Энэ бол нэг нь өгдөг, нөгөөх нь авдаг зарчим буюу энэ нөхцөлд аль нэг нь ямагт давуу талтай байдаг. Жишээ нь зээл хүссэн этгээд бөхийж, өгсөн нь гэдийж байгаа тохиолдолд хүү буух боломж хомс. Харин энэхүү харилцааг нээлттэй зах зээл буюу биржээр дамжуулснаар бүх тоглогчид аливаа арилжаанд ижил тэгш эрхтэй оролцох ба ингэснээр хүү дундаж руу тэмүүлэх боломжтой болох юм. Өөрөөр хэлбэл, бүгд нэг сагсанд байх учир нэг нь гэдийж, нөгөөх нь бөхийдөг байдал халагдана гэсэн үг. Түүнчлэн, санхүүгийн зах зээл дээрх хөрөнгийн хөрвөх чадварыг сайжруулснаар нэг төгрөгийг аль болох олон удаа эргэлдүүлж хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжтой. Энэ нөхцөлд хүүний асуудал өөр түвшинд яригдана. Иймд хөрөнгийн зах зээлийг эрс идэвхжүүлэх явдал нэн чухал байгаа.

-Хөрөнгийн бирж өөрөө өөрийгөө зохицуулах байгууллага болсон. Энэ нь хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд нэг хөшүүрэг болох уу?


Санхүүгийн зохицуулах хороо биржийг өөрийгөө зохицуулах байгууллага болгох нь эдийн засагт үр өгөөжтэй

гэж үзэн шийдвэр гаргасан. Энэ бол бидэнд олгосон маш том итгэл юм. Өөрийгөө зохицуулах байгууллага гэдэг нь үнэт цаасны зах зээлийн хуульд заасны дагуу гишүүд, мэргэжлийн оролцогчиддоо хяналт тавих, үнэт цаасны зах зээл дээр хэм хэмжээг тогтоох зэрэг эрхтэй болж байгаа юм. Өөрөөр хэлбэл, Санхүүгийн зохицуулах хорооны эрх хэмжээний тодорхой хэсгийг Хөрөнгийн бирж өөр дээрээ шилжүүлэн авч байгаа юм. Үүнийг дагаад тодорхой хэмжээгээр эрх, үүрэг өөрчлөгдөж байна. 2016 оны нэгдүгээр сарын 1-нээс шинэ журам мөрдөж эхэлсэн. Өмнө нь үнэт цаас гаргая гэхээр эхлээд Санхүүгийн зохицуулах хороонд хянаж зөвшөөрөх эсэх шийдвэрийг гаргана, тэгээд Хөрөнгийн бирж дээр ирээд дахиад л шалгадаг байсан. Үнэт цаас гаргах хүсэлтээ өгөөд хагас жил болсон жишээ ч байдаг юм билээ. Нэг ажлыг хоёр хийхээр хугацаа алдаж, удна шүү дээ. Шинэ бүртгэлийн журмаар энэ бүгдийг цэгцэлж, давхардалгүй, шуурхай, өгөөжтэй, хүртээмжтэй, зохистой байхаар өөрчилсөн байгаа. Бүртгэлээс гадна хяналт шалгалт, арилжааны, гишүүнчлэлийн, мэдээллийн журам бий. Хуучин маш олон журамтай байсныг цэгцэлж одоо таван гол журамтай болсон.

-Иргэдэд банкинд мөнгөө хадгалуулж хүү авах биш, хөрөнгийн зах зээлд тоглогч болж өгөөж хүртэх хүсэл бол бий. Гэвч мэдээлэл үнэхээр хангалтгүй байдаг. Мэдээллийн ил тод байдлыг шинэ шатанд гаргах бололцоо байна уу?

Хөрөнгийн зах зээл дээр бүтээгдэхүүн дутмаг, мэдээлэл түгээх нь учир дутагдалтай байгаа нь үнэн. Шинэ Үнэт цаасны зах зээлийн хуульд шаардлагатай зохицуулалтууд тусгагдсан. Тэгэхээр бирж дээрх боломжууд улам нээлттэй болж байгаа. Бид бүтээгдэхүүнээ нэмж, хэрэглэгчдэд мэдээллийг хүргэхэд анхааран ажиллаж байна.

Монголын хөрөнгийн бирж цахим хуудастаа томоохон өөрчлөлт хийж байгаа. Өмнө нь Хөрөнгийн бирж юу хийдэг вэ гэдгийг л яриад байдаг байсан. Энэ арга барилаа шинэчилж, хөрөнгийн зах дээр юу хийх боломжтой вэ гэсэн логик дээр үндэслэн мэдээллээ боловсруулж байна. Хүмүүст уншихад хялбар байх үүднээс ихэвчлэн инфографик байдлаар хүргэхээр зорьж байгаа. Хөрөнгө босгогч, хөрөнгө оруулагч, хэрхэн арилжаа хийх вэ гэх мэт тус тусдаа ангилалтай. Хувь хүн сонголтдоо хийгээд мэдээлэл авахад дөхөм гэж үзсэн. ■



нэртэйгээр, 210,000 ширхэг компанийн бондыг анх Монголын хөрөнгийн биржид бүртгүүлжээ.

2005.05.25 Анхны IPO гарав

“Монгол шилтгээн” ХХК анх 10 сая ширхэг хувьцаа гарган 1.0 сая ширхэг хувьцааг олон нийтэд санал болгож Монголын хөрөнгийн биржид бүтгүүлж, нээлттэй компани болжээ.

2011.02.25 – TOP 20 индекс түүхэндээ хамгийн өндөр үзүүлэлт үзүүлэв

Өнгөрсөн 25 жилийн хугацаанд TOP 20 индекс үзүүлэлт түүхэндээ хамгийн өндөрт буюу 32 954,97 нэгжид хүрсэн.

2011.04.27 Монгол Улсын Засгийн газар Лондонгийн хөрөнгийн биржтэй “Ажлын мастер гэрээ” байгуулав

Монгол Улсын Засгийн газраас дотоодын хөрөнгийн зах зээлийг шинэчилж, олон улсын жишигт

нийцүүлэн хөгжүүлэх зорилгын хүрээнд, 2011 оны дөрөвдүгээр сарын 07-ны өдөр Төрийн өмчийн хороо, Монголын хөрөнгийн бирж болон Лондонгийн хөрөнгийн бирж групп нь “Ажлын мастер гэрээ”-г байгуулж стратеги болон менежментийн түвшинд хамтран ажиллаж эхэлснээр дотоодын Хөрөнгийн зах зээлийн шинэчлэлийн ажил эхэлсэн

2012.07.02 “МИЛЛЕННИУМ АЙ ТИ” Арилжаа, Төлбөр, Тооцоо, Хяналт, Хадгаламжийн цогц системийг зах зээлд нэвтрүүлэв.

Дотоодын хөрөнгийн зах зээлийн програм хангамжийн шинэчлэх зорилгыг хэрэгжүүлж “МИЛЛЕННИУМ АЙ ТИ”-г суурилуулсан.

2013 он. Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг FTSE-ийн “Хөгжиж буй” (Frontier Market) зах зээлийн зэрэглэлд оруулахаар “Ажиглалтын жагсаалт”-

нд багтаасан байна

Олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгааны чиглэлээр тэргүүлэгч Их Британийн FTSE групптэй Санхүүгийн индекс боловсруулан тооцоолох чиглэлээр хамтран ажиллах гэрээг байгуулсан.

2013.10.21 Хоёрдогч зах зээлийн арилжаагаар хамгийн өндөр дүнтэй арилжаа хийгдэв

АПУ ХК-ийн 47,5 тэрбум төгрөгийн гүйлгээг нэг удаагийн хэлцлээр хийсэн

2015.12.24 Хамгийн их хөрөнгө босгосон IPO







“МИК холдинг” ХК нь олон нийтэд 3,1 сая ширхэг хувьцааг санал болгосноор 37,3 тэрбум төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлсэн.

2015 он. Түүхэн дээд арилжаа хийгдлээ


Нийт 546.4 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдлээ. ■

Тооны хэлээр

Хөрөнгийн захын 25 жилийн түүхэн статистик



Ногдол ашиг тараасан ХК




Арилжигдсан нийт тоо ширхэг



ТОП 20 индекс



IPO-г олон нийтэд санал болгох




Бүртгэлтэй ХК


■ Хувийн өмчит ■ Төрийн өмчит

28,047,018	9,869,854
35,264,129	25,648,51
47,809,985	35,617,85
37,483,016	58,695,75
109,087,378	81,257,84
110,989,460	89,326,57
63,854,969	205,159,0
117,328,392	155,632,4
173,825,142	99,825,14
182,895,605	91,378,41
182,191,692	475,076,6
235,689,565	988,947,5
261,928,954	1,752,809
284,805,166	1,876,501
403,855,556	1,866,939
636,043,697	1,855,073
1,170,516,729	1,854,695
1,242,405,445	1,854,619
831,209,111	1,854,363
904,284,983	1,881,180
2,680,094,031	2,088,231
2,643,435,656	2,038,529
2,716,438,114	2,303,873
2,813,572,583	2,991,104

Шинээр хувьцаа гаргасан ХК (сая ширхэг)

■ Унийн дүн ■ Тоо ширхэг





Гишүүн үнэт цаасны компани

Үзүүлэлт	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Гишүүн компанийн тоо	29	29	29	29	29	30	30	42	42	43	42	34	26	26	24	25	29	41	45	45	76	80	79	62	58
Ажилчдын тоо	-	-	-	-	-	-	-	-	-	-	184	143	73	86	82	97	150	241	264	272	538	598	563	467	448
Брокер, дилер /БД/	-	-	-	-	-	-	-	-	-	-	42	34	26	26	24	24	21	21	24	25	46	46	47	35	32
БД, андеррайтер	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	5	15	17	13	23	18	17	13	12
БД, зөвлөх	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	3	4	4	2	15	9	8	6	4
БД, андеррайтер, зөвлөх	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	1	1	1	5	7	7	7	8	10

Хамгийн хамгийн

Анхны арилжаа	
Анхны анхдагч зах зээлийн арилжаа	1992 оны 02 сарын 07-ны өдөр хийгдсэн
Анхны хоёрдогч зах зээлийн арилжаа	1995 оны 08 сарын 28-ны өдөр хийгдсэн.
Анхны хэлцэл	“Монгол савхи” ХК-ийн нэг ширхэг хувьцааг 150 төгрөгөөр “Санар ҮЦК” ХХК зарж “Мэргэн Санаа ҮЦК” ХХК худалдан авсан
Бондын зах зээл	
Засгийн газрын бондын анхны арилжаа:	1996 оны 10 сарын 25-ны өдөр 7684 ширхэг Засгийн газрын бондыг 70,1 сая төгрөгөөр арилжсан
Компанийн бондын анхны арилжаа:	2001 оны 06 сарын 09-ний өдөр “Барилга корпораци” ХХ-ийн нэг бүр нь 10,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, сарын 1,63 хувийн хүүтэй 10,875 ширхэг “Шинэ зүүн-210” бондыг 108.7 сая төгрөгөөр арилжсан
Хамгийн бага зардлаар нийлүүлэгдсэн бонд:	2010 оны 09 сарын 17-нд 30.0 тэрбум төгрөгийн жилийн 7.5-7.8 хувийн хүүтэй Засгийн газрын энгийн бондыг анх удаа хүүгээр нь дуудаж арилжсан. Ингэснээр Засгийн газрын бондын хүүгийн төлбөрийг 44.2 сая төгрөгөөр хэмнэсэн
Хамгийн их бондын арилжаа хийсэн өдөр	2011 оны 06 сарын 8-ны өдөр нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 360,000 ширхэг Засгийн газрын үнэт цаасыг нийт 36.0 тэрбум төгрөгөөр арилжсан
Индекс, Зах зээлийн үнэлгээ	
ТОП-20 индексийн дээд үзүүлэлт:	2015 оны 06 сарын 24 өдөр 15,711.95 хүрсэн түүхэн дэх хамгийн дээд үзүүлэлт юм
Нэг өдрийн доторх ТОП-20 индексийн өсөлт:	2005 оны 01 сарын 05-ны өдөр ТОП-20 индекс 57.6 хувиар өсч 502,15 нэгжээс 791,47 нэгжид хүрсэн байна
“MSE ALL” индексийн дээд үзүүлэлт:	2015 оны 06 сарын 23 өдөр 1,057.86 хүрсэн түүхэн дэх хамгийн дээд үзүүлэлт юм
Зах зээлийн нийт үнэлгээний дээд үзүүлэлт:	2016 оны 1 сарын 04-ны өдөр Зах зээлийн нийт үнэлгээ 1 их наяд 507,8 турбум төгрөгт хүрсэн
Хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй компани:	2011 оны 01 сарын 06-ны байдлаар Таван толгой ХК-ийн зах зээлийн үнэлгээ 311,3 тэрбум төгрөг

Үнэт цаасны компани

Хамгийн их харилцагчидтай :	“Андеррайтер, брокер дилерийн “БиДиСек ҮЦК” ХК нь нийт 182,764 харилцагчтай
Хамгийн их үнэт цаас арилжсан:	Андеррайтер, брокер дилерийн “Тэнгэр капитал ҮЦК” ХХК нь нийт 2,3 сая ширхэг үнэт цаас арилжиж, 230,4 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн нь нийт гүйлгээний 42 хувийг эзэлж байна.
Хамгийн их андеррайтер хийсэн:	Андеррайтер, брокер дилерийн “БиДиСек ҮЦК” ХК нь “Хай Би Ойл” ХК, “Монинжбар” ХК, “Женко түр бюро” ХК, “Хөх ган” ХК, “Нако түлш” ХК, “Түүл Сонгино усны нөөц” зэрэг ХК-иудын андеррайтер хийсэн.

ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛ

Үзүүлэлт	ХК-ийн нэр	Симбол	Тайлбар
Хамгийн их ногдол ашиг тараасан ХК	“Таван толгой” ХК	TTL	12,344,659,155,108.00
Хамгийн олон жил ногдол ашиг тараасан ХК	“Атар өргөө” ХК	ATR	19 жил
Хамгийн олон жил хувь нийлүүлэгчдийн хурал зарлан хуралдуулсан”	“Атар өргөө” ХК	ATR	24 жил
Хамгийн анх бүртгэгдсэн ХК	“Монгол шаазан” ХК	MSH	1991 оны 2-р сарын 21
Хамгийн сүүлд бүртгэгдсэн ХК	“Монгол шуудан” ХК	MNP	2015 оны 12-р сарын 15
Хамгийн их хувьцаатай ХК	“БЭРЭН МАЙНИНГ” ХК	BRM	1,740,813,320
Хамгийн их зах зээлийн үнэлгээтэй ХК	АПУ ХК	APU	289,424,879,200.00
Хамгийн их хувьцаа эзэмшигчтэй ХК	“Женко түр бюро” ХК	JTB	51783 хувьцаа эзэмшигчтэй
“Нэгж хувьцаанд хамгийн өндөр ногдол ашиг тараасан ХК”	“Таван толгой” ХК	TTL	2010 он 130,000 төг

СИМБОЛ	ҮНЭТ ЦААС	2015.12.31	Хамгийн өндөр ханштай 10 хувьцаа	
SUU	СҮҮ	98,000.00	“Сүү” ХК-ны хувьцаа 2000 онд 100 төгрөг байсан бол 2015 онд 98,000 хүртэл өссөн байна.	980.00
ATR	АТАР ӨРГӨӨ	65,000.00	“Атар өргөө” ХК-ны хувьцаа 1999 оны 12 сарын 09-ны өдөр 511 төгрөг байсан бол 2015 онд 65,000 хүртэл өссөн байна.	127.20
BNG	БАЯНГОЛ ЗБ	48,000.00	“Баянгол зочид буудал” ХК-ны хувьцаа 1999 оны 12 сарын 10-ны өдөр 905 төгрөг байсан бол 2015 онд 48,000 хүртэл өссөн байна.	53.04
SUL	ГАЗАР СҮЛЖМЭЛ	43,600.00	“Газар сүлжмэл” ХК-ны хувьцаа 1999 оны 12 сарын 20-ны өдөр 60 төгрөг байсан бол 2015 онд 43,000 хүртэл өссөн байна.	716.67
BUK	УБ БҮК	39,600.00	“УБ-БҮК” ХК-ны хувьцаа 2000 оны 01 сарын 13 өдөр 25 төгрөг байсан бол 2015 онд 39,000 хүртэл өссөн байна.	1,560.00
TMZ	ТӨМРИЙН ЗАВОД	30,000.00	“Төмрийн Завод” ХК-ны хувьцаа 2000 оны 1 сарын 31-ны өдөр 3 төгрөг байсан бол 2015 онд 30,000 хүртэл өссөн байна.	10,000.00
DAN	ДАРХАН ХӨВӨН	27,000.00	“Дархан хөвөн” ХК-ны хувьцаа 1999 оны 12 сарын 21-ны өдөр 13 төгрөг байсан бол 2015 онд 27,000 хүртэл өссөн байна.	2,076.92
TAV	ТАВ	24,000.00	“Тав” ХК-ны хувьцаа 2000 оны 11 сарын 14-ны өдөр 10 төгрөг байсан бол 2015 онд 24,000 хүртэл өссөн байна.	2,400.00
DZG	ДАРХАН ЗБ	20,000.00	“Дархан ЗБ” ХК-ны хувьцаа 2000 оны 01 сарын 25-ны өдөр онд 1,171 төгрөг байсан бол 2015 онд 20,000 хүртэл өссөн байна.	17.08
GHC	ГАН ХИЙЦ	18,450.00	“Ган хийц” ХК-ны хувьцаа 2000 оны 05 сарын 17-ны өдөр 100 төгрөг байсан бол 2015 онд 18,450 хүртэл өссөн байна.	184.50

2015 оны үнэт цаасны арилжааны мэдээлэл

Хувьцааны арилжаа


2015 оны арванхоёрдугаар сарын 31-ны өдрийн байдлаар нийт 252 удаагийн арилжаагаар 125 компанийн 35.8 сая ширхэг хувьцааг 30.5 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын үнэт цаасны 54 удаагийн арилжаагаар 5.4 сая ширхэг үнэт цаасыг 510.3 тэрбум төгрөгөөр арилжиж, нийт 546.4 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Нийт гүйлгээний үнийн дүнгийн 5.58 хувь буюу 30.5 тэрбум төгрөгийг хувьцааны арилжааны гүйлгээний дүн, 93.39 хувь буюу 510.3 тэрбум төгрөгийг Засгийн газрын үнэт цаас, 0.09% буюу 0.5 тэрбум төгрөгийг компанийн бонд, 0.93 хувь буюу 5.1 тэрбум төгрөгийг Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааны гүйлгээний дүн тус тус эзэлж байна.

2015 оны байдлаар хийгдсэн арилжааны хэмжээг өмнөх онтой харьцуулахад

Арилжааны үзүүлэлтүүд	2014 онд	2015 онд
Арилжигдсан үнэт цаасны тоо (сая ширхэг)	52.1	41.3
Нийт үнийн дүн (тэрбум төг)	60.4	546.4

Нийт үнийн дүнд эзлэх хувь



Тайлант хугацаанд өдөрт дунджаар 2.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийж, 163.9 мянган ширхэг үнэт цаас арилжсан байна.

Идэвхтэй арилжигдсан 30 үнэт цаас

Үнэт цаас	Арилжигдсан ширхэг	Эрэмбэ	Үнэт цаас	Үнийн дүн
ТАВАН ТОЛГОЙ	9,284,569	1	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	1,574,306,040
Э-ТРАНС ЛОЖИСТИКС	6,882,941	2	ТАВАН ТОЛГОЙ	1,540,167,671
ХӨХ ГАН	4,610,340	3	БИ ДИ СЕК	964,936,010
УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	2,875,251	4	АПУ	952,920,336
РЕМИКОН	2,650,464	5	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	698,423,575
МЕРЕКС	1,919,507	6	ТАЛХ ЧИХЭР	524,922,580
ГЕРМЕС ЦЕНТР	1,636,131	7	ХӨХ ГАН	520,770,723
ХОРИН ХОЁРДУГААР БААЗ	1,318,569	8	МАТЕРИАЛИМПЕКС	368,238,870
БИ ДИ СЕК	546,970	9	ГОВЬ	362,709,570
ЖЕНКО ТУР БЮРО	339,628	10	22-р БААЗ	270,306,645
АПУ	266,301	11	ГЕРМЕС ЦЕНТР	204,402,257
ТАЛХ ЧИХЭР	170,744	12	РЕМИКОН	196,458,625
ГОНИР	160,332	13	УБ-БУК	191,621,720
ОЛЛОО	155,819	14	СҮҮ	173,299,600
ХАЙ БИ ОЙЛ	105,968	15	МЕРЕКС	170,653,555
ӨНДӨРХААН	91,467	16	ДАРХАН НЭХИЙ	163,200,620
ЖИНСТ-УВС	90,476	17	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	133,676,150
МОНГОЛ САВХИ	72,112	18	МОНГОЛ КЕРАМИК	109,326,675
БАЯЛАГ НАЛАЙХ	64,388	19	ЕВРОФЁ АЗИА	97,394,900
БИНСЭ ХК	61,951	20	ГАЗАР СУЛЖМЭЛ	91,239,890
МОНИНЖБАР	60,643	21	ШАРЫН ГОЛ	89,959,677
МОНГОЛ МАХ ЭКСПО	59,252	22	ГУТАЛ	86,724,140
БИШРЭЛТ ИНДАСТРИАЛ	54,611	23	МАХИМПЕКС	84,375,541
УУЖИМ ХАНГАЙ	46,529	24	ГАН ХЭРЛЭН	82,058,830
ГОВЬ	43,631	25	БАГАНУУР	78,635,668
БҮТЭЭЛЧ ҮЙЛС	39,212	26	АТАР-ӨРГӨӨ	74,055,000
ЕВРОФЁ АЗИА	30,415	27	МОНГОЛ САВХИ	72,286,974
БАГАНУУР	29,357	28	ДОРНОД АВТО ЗАМ	64,732,500
ХӨВСГӨЛ ХУНС	28,732	29	МОГОЙН ГОЛ	61,561,420
МАХИМПЕКС	25,978	30	МОНГОЛ МАХ ЭКСПО	58,279,059
Нийт	33,722,288			10,061,644,821
Нийтэд эзлэх хувь	99.02			92.44

Идэвхитэй арилжигдсан 30 үнэт цаасны тоо ширхэг нь нийт арилжигдсан ширхэгийн 99.02 хувь, үнийн дүнгийн 92.44 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд 125 компанийн үнэт цаас арилжигдсанаас өмнөх оны мөн үетэй харьцуулахад 39 компанийн үнэт цаасны ханш өсч, 69 компанийн үнэт цаасны ханш буурч, 17 компанийн үнэт цаасны ханш тогтмол байна.


Ханшийн өсөлттэй 20 үнэт цаас

Үнэт цаас	Хаалтын ханш 2014.12.31	2015.12.31	Ханшийн өөрчлөлт /төг/	Өөрчлөлт хувиар
СТАНДАРТ ПРОПЕРТИ ГРУПП	10.00	46.44	36.44	364.40
ТЕХНИК ИМПОРТ	695.00	1,605.00	910.00	130.94
ГУТАЛ	9,500.00	17,500.00	8,000.00	84.21
УЛААНСАН	1,000.00	1,592.00	592.00	59.20
ТАХЬ-КО	11,000.00	16,990.00	5,990.00	54.45
ТҮШИГ УУЛ	300.00	450.00	150.00	50.00
УУЖИМ ХАНГАЙ	155.00	225.93	70.93	45.76
ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГ	227.27	315.00	87.73	38.60
МОНГОЛ НЭХМЭЛ	4,100.00	5,400.00	1,300.00	31.71
БҮТЭЭЛЧ ҮЙЛС	917.00	1,150.00	233.00	25.41
УЛААНБААТАР ХИВС	12,400.00	15,100.00	2,700.00	21.77
Э-ТРАНС ЛОЖИСТИКС	99.00	120.00	21.00	21.21
МОН НАБ	1,350.00	1,612.00	262.00	19.41
МОН-ИТ БУЛИГААР	8,000.00	9,500.00	1,500.00	18.75
ЖУУЛЧИН ГОВЬ	3,600.00	4,250.00	650.00	18.06
ХӨСӨГ ТРЕЙД	1,200.00	1,400.00	200.00	16.67
МОНГОЛ ШИЛТГЭЭН	690.00	800.00	110.00	15.94
ХӨВСГӨЛ ХУНС	591.15	680.00	88.85	15.03
ХАРХОРИН	1,400.00	1,610.00	210.00	15.00
ЕВРО АЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ	21.16	24.33	3.17	14.98

Ханшийн бууралттай 20 үнэт цаас

Үнэт цаас	Хаалтын ханш 2014.12.31	2015.12.31	Ханшийн өөрчлөлт /төг/	Өөрчлөлт хувиар
УВС ЧАЦАРГАНА	2,550.00	950.00	-1,600.00	-62.75
МОНГОЛ МАХ ЭКСПО	3,780.00	1,550.00	-2,230.00	-58.99
ИХ БАРИЛГА	11,000.00	5,000.00	-6,000.00	-54.55
АГРОТ ЕХ ИМПЕКС	2,950.00	1,380.00	-7,995.00	-53.22
МАТЕРИАЛИМПЕКС	14,900.00	7,005.00	-1,570.00	-52.99
МОННООС	4,700.00	2,430.00	-48.96	-48.30
БЭРХ УУЛ	3,579.00	1,900.00	-2,270.00	-46.91
РЕМИКОН	99.00	54.00	-1,679.00	-45.45
АВТО ИМПЕКС	4,000.00	2,332.00	-1,668.00	-41.70
МОГОЙН ГОЛ	9,900.00	5,865.00	-4,035.00	-40.76
МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	1,300.00	800.00	-500.00	-38.46
БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК	784.50	490.00	-294.50	-37.54
БАЯЛАГ НАЛАЙХ	689.00	440.00	-249.00	-36.14
МОНИНЖБАР	210.00	135.00	-75.00	-35.71
БИШРЭЛТ ИНДАСТРИАЛ	2,470.00	1,600.00	-870.00	-35.22
ШАРЫН ГОЛ	5,900.00	3,852.00	-2,050.00	-34.71
ТАВАН ТОЛГОЙ	4,400.00	2,950.00	-197.14	-32.95
ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	800.00	550.00	-1,357.00	-31.25
ШИВЭЭ ОВОО	4,999.00	3,523.00	-250.00	-29.53
НАКО ТҮЛШ	280.00	200.00	-680.00	-28.57

Хувьцааны арилжааны үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулав



Анхдагч зах зээлийн арилжаа

Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон гаргасан “Бинсэ” ХК-ийн 150.8 мянган ширхэг хувьцааг 112.2 сая төгрөгөөр, “БиДиСек” ХК-ийн 189 ширхэг хувьцааг 405.6 мянган төгрөгөөр, “Эрчим инженеринг” ХХК-ийн 50 мянган ширхэг Эрчим бондыг 500 сая төгрөгөөр, “МИК Холдинг” ХК-ийн 1.6 сая ширхэг хувьцааг 19.5 тэрбум төгрөгөөр тус тус анхдагч зах зээлд арилжсан байна.

Тайлант хугацаанд 54 удаа Засгийн газрын үнэт цаасны арилжаа явагдаж, 12, 28, 52, 156 долоо хоногийн хугацаатай нийт 5.4 сая ширхэг үнэт цаасыг 510.3 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлд 52.3 мянган ширхэг үнэт цаасыг 5.1 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

Багцын арилжаа

Тайлант хугацаанд багцын арилжаагаар нийт 21.2 сая ширхэг хувьцааг 3.1 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 10.34 хувийг эзэлж байна.

Зах зээлийн үнэлгээ


Нийт зах зээлийн үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 180.16 тэрбум төгрөгөөр буюу 12.49 хувиар буурч, 1 их наяд 262.5 тэрбум төгрөг болсон байна.

Хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй 30 компани

Үнэт цаасны нэр	/тэрбум төг/		
АПУ	289.42	ДАРХАН НЭХИЙ	20.17
ТАВАН ТОЛГОЙ	155.36	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	19.51
ГОВЬ	66.15	ТАЛХ ЧИХЭР	17.79
УБ-БУК	64.46	АТАР-ӨРГӨӨ	11.32
БАГАНУУР	51.81	МАХИМПЕКС	10.79
ШИВЭЭ ОВОО	47.28	СИЛИКАТ	10.43
ШАРЫН ГОЛ	39.18	ГЕРМЕС ЦЕНТР	9.63
БЭРХ УУЛ	36.22	МАТЕРИАЛИМПЕКС	9.58
МОНГОЛ СЕКЮРИТИЕС	36.00	АРИГ ГАЛ	8.18
СҮҮ	33.71	МОНГОЛ ШИЛТГЭЭН	9.25
БИ ДИ СЕК	32.96	ХӨХ ГАН	7.55
ГУТАЛ	28.33	ЖЕНКО ТУР БЮРО	7.50
ХАЙ БИ ОЙЛ	21.89	УЛААНБААТАР ХИВС	6.11
МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	20.70	НИЙСЛЭЛ ӨРГӨӨ	5.67
БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	20.31	Нийт	1,116.23
ТАХЬ-КО	20.22	Нийтэд эзлэх хувь	88.41

Зах зээлийн үнэлгээ өндөр 30 компанийн үнэлгээ нийт зах зээлийн үнэлгээний 88.41 хувийг эзэлж байна.


Зах зээлийн үнэлгээ



ТОП-20 индекс


Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 15737.17 нэгж, доод үзүүлэлт 11962.11 нэгж, дундаж үзүүлэлт 13434.24 нэгж байна.

ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1956.65 нэгжээр буюу 13.17 хувиар буурч, 12897.59 нэгж болсон байна.



MSE ALL индекс

Тайлант хугацаанд MSE ALL индексийн дээд үзүүлэлт 1057.89 нэгж, доод үзүүлэлт 854.84 нэгж, дундаж үзүүлэлт 953.29 нэгж байна.



“МИК Холдинг” ХК
үнэт цаас гаргагч

Монголын хөрөнгийн биржийн
1-р ангиллын шалгуурт тэнцсэн
А самбарын анхны Хувьцаат
компани боллоо.

Хөрөнгийн зах зээлд татан төвлөрүүлсэн
хөрөнгө оруулалтын хэмжээ

Нийт хувьцааны
15 хувийг буюу
3,106,398 ширхэг
хувьцааг олон
нийтэд нээлттэй
арилжлаа.


Анхдагч
зах зээлийн
арилжаагаар
37,276,776,000
төгрөгийг
хөрөнгийн зах
зээлээс
босголоо.

2015 оны ОТГОН,
оны өндөр
дүнтэй IPO
гаргагч
боллоо.

Анхдагч зах
зээлд хувьцаа
гаргаснаас хойш
21 хоног дотор
хувьцааны үнэ
210 төгрөг
буюу 1,8%-иар
өслөө.

МИК Холдинг ХК-ийн охин компани МИК ОССК ХХК нь 2013-2015 онд

 7 тусгай зөвшөөрлийн компани байгууллаа.

 2,1 их наяд төгрөгийн ипотекийн зээлээр баталгаажсан бонд гаргалаа.


 47,498 зээлийн дансыг хөтөлбөрт оролцогч арилжааны банкуудаас
шилжүүлж авлаа.

Бондын ангилал

Давуу эрхтэй
ИЗББ



Энгийн эрхтэй
ИЗББ



Сүүлийн 3 жилд өөрийн хөрөнгөө 9,3, нийт хөрөнгөө
101,4 дахин өсгөж хамгийн өндөр өсөлт үзүүллээ.




Холбоо барих:

СБД, 1-р хороо, 13-р хороолол, Энхтайваны өргөн чөлөө-19, 10 давхар

Утас: 976 11-328267 Факс: +976 11-317933 Цахим шуудан: info@mik.mn

Хөрөнгө босгогчдод

Танай компанид санхүүжилт шаардлагатай юу? Банкны зээл ганцхан таны сонголт биш юм!
Үнэт цаасыг бүртгэх хугацаа 20 хоног болж богинослоо.



Нийт 2 сар

Үзүүлэлтүүд	Хөрөнгийн бирж	Арилжааны банкнууд
Санхүүжилтийн хүү	Байхгүй	≈ 20%
Санхүүжилтийн хугацаа	Байхгүй	≈ 36 САР ХҮРТЭЛ
Санхүүжилтийн хэмжээ	Хязгаар байхгүй	Бизнесийн цар хүрээнээс хамаараад 1 тэрбум төг хүртэл
Тавигдах шаардлага:		
Үйл ажиллагаа явуулсан жил	0, 2, 3 жил	1 жилээс доошгүй
Барьцаа хөрөнгө /хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө/	Шаардлагагүй	Барьцаа хөрөнгө заавал шаардахаас барьцаа хөрөнгийн тодорхой хувиар зээл олгогдоно
Зээлийн сайн түүхтэй байх	Шаардлагагүй	Шаардлагатай
Бусад банк болон санхүүгийн байгууллагад зээлийн өргүй байх	Шаардлагагүй	Шаардлагатай
Хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх	Шаардлагагүй	Шаардлагатай

Хөрөнгийн зах зээлийг сонгосноор

● Хөрөнгийн зах зээлийг сонгосноор

IPO/ Олон нийтэд хувьцаагаа санал болгох боломжтой болно
Компани хөрөнгийн биржээр дамжуулан үнэт цаасаа анх удаа нийтэд санал болгон гаргах замаар өөрт хэрэгцээт санхүүжилт татах үйл явц юм.

● Бонд гаргах боломжтой болно

Компани шаардлагатай мөнгөн хөрөнгийг тодорхой хугацааны дараагаар тодорхой хэмжээний хүүтэйгээр эргэн төлөхийг баталж өрийн бичгийг хөрөнгийн биржээр арилжиж хөрөнгө босгоно.

● Нэмэлт хувьцаа гаргах боломжтой болно

Хувьцаат компани нь шаардлагатай мөнгөн хөрөнгийг хөрөнгийн бирж дээр нэмэлт хувьцаа гарган арилжих замаар санхүүжилт татах үйл явц юм.

IPO/олон нийтэд хувьцаагаа санал болгох

Шинэ бизнес төлөвлөгөөтэй, санхүүжилт хэрэгтэй компани хөрөнгийн зах зээлийг сонгож барьцаа хөрөнгө шаардлагагүйгээр хэрэгтэй санхүүжилтийг татан төвлөрүүлэх юм. Монголын хөрөнгийн биржээр дамжин олон компани бизнесээ өргөжүүлж чадсан.

Монголын хөрөнгийн бирж дээр амжилттай үнэт цаас гаргагчид: 2005 оноос хойш 16 компани Монголын хөрөнгийн биржид шинээр хувьцаа гарган нийт 100 тэрбум төгрөгийг хөрөнгийн зах зээлээс босгож чаджээ. Танай компанид ч бас хэрэгтэй хөрөнгийг татан төвлөрүүлэх боломж байна.



2016 оны байдлаар хамгийн сүүлд IPO хийсэн компани “Монгол Шуудан” ХК юм. Тус компаний анхдагч зах зээлийн арилжаа өнгөрсөн оны арванхоёрдугаар сарын 28-наас 2016 оны нэгдүгээр сарын 6-ны хооронд явагдаж, 12.6 тэрбум төгрөгийн хувьцааны захиалга ирсэн нь нийлүүлтээсээ 2 дахин их байсан юм.

Үнэт цаас гаргахын ач холбогдол



Хөрөнгийн эх үүсвэр татах хамгийн тохиромжит хувилбар:

Компани хүссэн үедээ хямд өртөгтэй, урт хугацаат санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх боломжтой бөгөөд барьцаа хөрөнгө шаардлагагүй.



Зээлийн дарамтгүй үйл ажиллагаа явуулах:

Хувьцаа гаргаснаар зээлдүүлэгчдэд төлдөг үндсэн болон хүүгийн төлбөр төлөх шаардлагагүй.



Гадаадын зах зээлээс санхүүжилт татах боломж:

Монголын хөрөнгийн биржид бүртгүүлснээр хамтын ажиллагаа бүхий гадаадын биржүүдэд бүртгүүлэх хувьцаагаа давхар арилжиж, гадаад санхүүжилт татах боломж цаашид нээгдэнэ.



Компанийн зах зээлийн үнэ цэнэ бодитоор тодорхойлогдоно:

Хувьцааны эрэлт нийлүүлэлт дээр үндэслэн компанийн зах зээлийн үнэ цэнэ бодитой тодорхойлогдоно.



Нэр хүнд өсөх, компанийн засаглалын сайн тогтолцоо бүрдэх боломж:

Хөрөнгийн биржид бүртгүүлж нээлттэй компани болсноор компанийн нэр хүнд өсч олон нийтэд танигдах, харилцагчдын хүрээ өргөжих, компанийн засаглалын сайн тогтолцоо бүрдэнэ.



Чадварлаг боловсон хүчин, сайн менежментийн баг бүрдүүлэх боломж:

Нээлттэй ил тод хяналттай болсноор сайн менежменттэй, чадварлаг, хариуцлагатай удирдлагын баг бүрдэх боломжтой.

Компанийн бонд

Зөвхөн IPO хийгээд зогсох биш, компанийн бонд гаргах, нэмэлт хувьцаа гаргах боломж таньд, танай компанид бий.

Корпорацийн бонд яагаад гаргах хэрэгтэй вэ?

Компани өөрийн ирээдүйд орж ирэх орлого, бизнесийн санаа, төсөл төлөвлөгөөгөө хөрөнгө оруулагчдад танилцуулж, барьцаа хөрөнгө тавихгүйгээр хөрөнгийн биржээр дамжуулан өрийн бичиг гаргах замаар хөрөнгө босгох боломжтой юм.

2001 оноос хойш 13 компани Монголын хөрөнгийн бирж дээр компанийн бонд гарган нийт 17.8 тэрбум төгрөгийн хөрөнгийг босгож чадсан.



2015 оны наймдугаар сард хамгийн анхны даатгагдсан компанийн бондыг “Эрчим инженеринг” ХХК гаргасан бөгөөд тус компанийн бондын арилжааны захиалга нийлүүлэлтээсээ 4.7 дахин их байж, шаардлагатай 2.4 тэрбум төгрөгийн санхүүжилтыг босгож чадсан.


Бонд гаргах зардлын хэмжээ

Компаний бонд гаргах зардал	Арилжааны банкнаас зээл авахад гарах зардал
Хүүгийн зардал / 18%	Хүүгийн зардал
Андеррайтерийн хөлс /2.0%/	Зээлийн олгосон үйлчилгээний шимтгэл
Аудит, хуулийн дүгнэлт гаргуулах үйлчилгээний хөлс /0.15%/	Тэмдэгтийн хураамж /10,000-300,000 төгрөг/
СЗХ-ны зохицуулах үйлчилгээний хөлс /500.0 төгрөг/	Зээлийн даатгал= 0.3% Хөрөнгийн даатгал =0.5%
МХБ-ийн үйлчилгээний хөлс /2.0 сая + 0.05%/	
1. Хүүгийн зардал 90,000,000	1. Хүүгийн зардал 100,000,000
2. Нэг удаад гарах зардал 14,000,000	2. Нэг удаад гарах зардал 9,000,000
3. Үндсэн төлбөр 500,000,000	3. Үндсэн зээлийн төлөлт 500,000,000
Нийт зардал 604,000,000 төгрөг	Нийт зардал 609,000,000 төгрөг

“А” компани 500 сая төгрөгийн хөрөнгийг зах зээлээс босгож байна гэж үзвэл үнэт цаас гаргахад шаардагдах зардлын хэмжээ.

Бондын төрөл

Компани нь өөрийн төлбөрийн чадвар, санхүүгийн нөхцөл байдлаас хамааран таван төрлийн компанийн бонд гаргаж болдог нь нэг давуу тал юм.



Нэмэлт хувьцаа гаргах

Хувьцаагаа олон нийтэд санал болгосноор, нэмэлт хувьцаа гаргаж санхүүжилт татахад маш хялбар.


Бүртгэлтэй компаниуд яагаад нэмэлт хувьцаа гаргах хэрэгтэй вэ?

Кэйс 1 Хувьцааны үнийн эрсдэлийг бууруулна. Үнэт цаасны үнийн хэлбэлзэл, хэлбэлзлийн далайц буурснаар компанийн зах зээлийн үнэлгээ харьцангуй тогтворжино. Ялангуяа хувьцааны хэт өндөр төвлөрөлтэй компаниудын хувьд 10 ширхэг хувьцаа биржээр арилжаалагдахад үнэ нь савлаж байна.

Кэйс 2 Эрэлт ихтэй. Хөрөнгө оруулалтын өгөөжөөс илүү хөрөнгө оруулалтын диверсификаци хийх хүсэлтэй маш олон хадгаламж эзэмшигчид бий болсон тул эрэлт хангалттай. Тиймээс үнийн эрсдэл бага.

Кэйс 3 Зах зээлийн нэр хүнд, сигмент, хэрэглэгчид, дэмжигчдийн тоо нэмэгдэнэ. “А” компанийн хувьцаа эзэмшигч аль болох “А” компанийн бүтээгдэхүүнийг хэрэглэнэ.

Амжилттай нэмэлт хувьцаа гаргагчид: Нийт 13 хувьцаат компани Монголын хөрөнгийн бирж дээр нэмэлт хувьцаа гарган 56.9 тэрбум төгрөгийн санхүүжилтыг татсан байна. Доорх хүснэгтэд нэмж хувьцаа гаргасан компанийн мэдээллийг харууллаа. Үүнд “Шарын гол” ХК нь хамгийн их хөрөнгө буюу 18.9 тэрбум төгрөгийн санхүүжилтыг татжээ.



Нэмэлт хувьцаа гаргах зардлын хэмжээ

Нэмэлт хувьцаа гаргахад гаргах зардал

- Андеррайтерийн хөлс /2.0%/
- Зөвлөх компаниудын хөлс /30-50 сая төгрөг/
- СЗХ-ны зохицуулах үйлчилгээний хөлс /200,000 төгрөг/
- МХБ-ийн үйлчилгээний хөлс /50 сая төгрөг /

Нэмэлт хувьцаа гаргах зардал
Нийт 80,200,000 төгрөг

“А” компани 500 сая төгрөгийн хөрөнгийг зах зээлээс босгож байна гэж үзвэл үнэт цаас гаргахад шаардагдах зардлын хэмжээ.



Арилжааны банкнаас зээл авахад гарах зардал

- Хүүгийн зардал
- Зээлийн олгосон үйлчилгээний шимтгэл
- Тэмдэгтийн хураамж /10,000-300,000 төгрөг/
- Зээлийн даатгал= 0.3% Хөрөнгийн даатгал =0.5%


1. Хүүгийн зардал 100,000,000
 2. Нэг удаад гарах зардал 9,000,000
 3. Үндсэн зээлийн төлөлт 500,000,000
- Нийт зардал 609,000,000 төгрөг

Дан ганц компанийн бонд, нэмэлт хувьцаа гаргаад зогсохгүй, танай компани цаашид гадаадын хөрөнгийн биржүүдэд давхар бүртгэл хийлгэх, хадгаламжийн бичиг гаргах боломжийг нээж өгнө. Хөрөнгийн зах зээл таны сонголт мөн байх болно. ■


Хөрөнгө оруулагчдад



Зах зээлийн бүтэц




Үнэт цаасны зах зээлд оролцох



Үнэт цаасны зах зээлд оролцохыг хүсч буй хөрөнгө оруулагч та:
 Үнэт цаасны компани сонгон / брокер дилерийн компани/ өөрийн харилцах дансыг нээлгэж, өөрийн сонирхсон үнэт цаасыг захиалж арилжаанд оролцох боломжтой. Тухайн ҮЦК-н клирингийн банкинд үнэт цаасны төлбөр тооцоог гүйцэтгэхэд ашиглагдах мөнгөн хөрөнгийн дансыг нээлгэж бэлэн мөнгөө байршуулна.

Арилжаа хэрхэн явагддаг вэ?



Данс хэрхэн нээлгэх вэ?



ҮНЭТ ЦААСНЫ ДАНСТАЙ ЭСЭХЭЭ ШАЛГАХ

- * “ҮЦТТТХТ” ХХК- дээр өөрийн биеэр очиж шүүлгэх
- * NET.SCHCD.MN цахим хаягаар орж регистрийн дугаараар шүүх

ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО ТӨВЛӨРСӨН ХАДГААМЖИЙН ТӨВ

Нүүр | Регистр | Тусламж

Та регистрийн дугаараа оруулна уу. /Регистрийн дугаарыг зөвхөн криллээр бичиж ёстойг анзаарна уу./

ЦЭ85061610

Иргэн Та Монгол Улсын Засгийн Газраас өлгөсөн "Эрдэнэс тавантолгой" ХК -ийн 536 ширхэг хувьцаа эзэмшиж байна. Та Төвлөрсөн хадгалагчинд данс нээлгэсэн байна. Та дараах Брокер Дилерийн Компанид очиж үйлчлүүлнэ уу.

Би дн сек
Хаяг: Улаанбаатар, СБД, Залуучуудын өргөн чөлөө 27/1 Байр /Сансрын тунцаг руу өгсдөг зам дагуу, Орчлон дунд сургуулийн харацдаа, мд байрлах 6 дэвхар барилга/. Утас: 70112845, 313108, 321763

Данс хэрхэн нээлгэх вэ?

“А” КОМПАНИ



“А” КОМПАНИ ХУВЬЦАА ГАРГАН КОМПАНИЙХАА ТОДОРХОЙ ХЭСГИЙГ ХЭДЭН ЗУУН ХЭСЭГТ ХУВААН ХУВЬЦАА БОЛГОН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ЗАРАХ ЗАМААР САНХҮҮЖИЛТ ТАТАЖ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ӨРГӨТГӨНӨ.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ



“А” КОМПАНИЙ ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВСНААР:
 - НООГДОЛ АШИГ ХҮРТЭХ
 - ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛД ОРОЛЦОЖ, САНАЛ ӨГӨХ
 - КОМПАНИ ТАТАН БУУСНЫ ДАРАА ЭД ХӨРӨНГӨ ХУДАЛДСАНААС ХУВЬ ХҮРТЭХ ЭРХТЭЙ БОЛНО

ӨӨРИЙН ХӨРӨНГӨӨР “А” КОМПАНИЙН ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВСНААР ТЭРХҮҮ КОМПАНИЙ ХЭСЭГ ХУВИЙГ ЭЗЭМШИГЧ БОЛЖ БАЙНА ГЭСЭН ҮГ ЮМ.



ӨӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ХУВЬЦААНААС 2 ТӨРЛИЙН АШИГ ХҮРТЭХ БОЛОМЖТОЙ.



ХАНШИЙН ЗӨРҮҮНЭЭС АШИГ ХҮРТЭХ

“А” КОМПАНИЙ ХУВЬЦААНЫ ҮНЭ ӨСВӨЛ ХУВЬЦААГАА ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР АНХ ХУДАЛДАН АВСНААСАА ӨНДӨР ҮНЭЭР ЗАРЖ АШИГ ОЛОХ БОЛОМЖТОЙ.



НООГДОЛ АШИГ ХҮРТЭХ

КОМПАНИ АМЖИЛТАА, АЖИЛЛАСАН ТОХИОЛДОЛД АШГААСАА ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ БУЮУ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДДЭЭ НОГДОЛ АШИГ ОЛГОНО.

Ногдол ашиг гэж юу вэ

ХУВЬЦААТ КОМПАНИ ОЛСОН АШГААСАА ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ТАРААЖ БУЙГ НОГДОЛ АШИГ ГЭНЭ. НОГДОЛ АШГИЙГ МӨНГӨН БОЛОН ХУВЬЦААГААР ГЭСЭН 2 ЗАМААР ТАРААДАГ.



Компани ашигтай ажилласнаар, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу ногдол ашиг тараах эсэхийг шийдвэрлэнэ

№	КОМПАНИЙ НЭР	НЭГЖ ХУВЬЦААНД НООГДОХ НОГДОЛ АШИГ	ХУВЬЦААНЫ ТОО	НИЙТ ТӨЛӨГДСӨН НОГДОЛ АШИГ
1	ГАЗАР СҮЛЖМЭЛ ХК	7233.39	65,362	472,788,837
2	БАРИЛГА КОРПОРАЦИ ХК	5500.00	40,662	223,641,000
3	ТАВАНТОЛГОЙ ХК	766.00	52,665,200	40,341,543,200
4	ТЭЭВЭР ДАРХАН ХК	400.00	163,349	65,339,600
5	БАЯНГОЛЬ ХК	355.00	423,065	150,188,075
6	ГУТАЛ ХК	349.00	1,618,684	564,920,716
7	УЛААНБААТАР ЗОЧИД БУУДАЛ ХК	330.00	335,297	110,648,010
8	АТАР-ӨРГӨӨ ХК	300.00	174,136	52,240,800
9	ГАН-ХЭРЛЭН ХК	300.00	99,899	29,969,700
10	ХҮРД ХК	253.00	135,266	34,222,298

Засгийн газрын үнэт цаас

ЗГЖҮЦ-НД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ДАВУУ ТАЛУУД



ЗАСГИЙН ГАЗРЫН АЛИВАА ӨРИЙН БИЧИГ, ҮНЭТ ЦААС НЬ ХАМГИЙН ЭРСДЭЛГҮЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГСЭЛД ТООЦОГДДОГ.

ХАМГИЙН ЭРСДЭЛГҮЙ



ХҮН АМЫН ОРЛОГЫН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН 16.1.16, АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН 18.1.1-Д ТУС ЗААСНААР ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР, ХҮҮ НЬ ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨГДӨНӨ.

ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨГДСӨН




ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮ, ӨГӨӨЖ НЬ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАРЧМААР ТОГТООДОГ ТУЛ ЗАХ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛТАЙ УЯЛДАЖ ӨНДӨР ӨГӨӨЖТЭЙ БАЙДАГ.

ӨНДӨР ӨГӨӨЖТЭЙ

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ НЬ ХӨРВӨХ ЧАДВАРТАЙ БАЙДАГ БУЮУ ҮНЭТ ЦААСЫГ ХУГАЦАА НЬ ДУУСАХААС ӨМНӨ АЛИВАА ТОРГУУЛЬГҮЙГЭЭР БУСАД ЭТГЭЭДЭД ХУДАЛДАХ, БЭЛЭГЛЭХ, БАРЬЦААЛАХ БҮРЭН БОЛОМЖТОЙ.



ХӨРВӨХ ЧАДВАРТАЙ

ЗГЖҮЦ НЬ ХУВЬ ХҮН АЖ АХУЙН НЭГЖИД ЗОРИУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГСЭЛ БӨГӨӨД НЭГЖ БҮР НЬ 100,000.0 НЭРЛЭСЭН ҮНЭТЭЙ, ТОГТСОН ХУГАЦААНД ХҮҮ ТӨЛДӨГ /ТОГТМОЛ ХУГАЦААНД ЭСХҮЛ ҮНЭТ ЦААСНЫ ХУГАЦААНЫ ЭЦЭСТ/ ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БИЧИГ ЮМ.



Засгийн газрын үнэт цаас

Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаасны арилжаа нь долоо хоног бүрийн ДАВАА гаригт болдог бөгөөд 12 долоо хоног /3 сар/, 28 долоо хоног /6 сар/ болон 52 долоо хоног /1жил/ гэсэн богино хугацаатай үнэт цаас, 3 жил, 5 жил гэсэн урт хугацаат үнэт цаас тус тус арилжигддаг



1. БРОКЕР, ДИЛЕРИЙН КОМПАНИ /ҮЦК/ ДЭЭР ОЧИЖ ХУВЬ ХҮНИЙ БОЛОН АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭР ДЭЭР ҮНЭТ ЦААСНЫ ДАНС НЭЭЛГЭНЭ.
2. ҮЦК НЬ ТАНЫ НЭРИЙН ӨМНӨЭС ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИД ҮНЭТ ЦААСНЫ ДАНС НЭЭЖ ӨГӨХ БА ДАНСНЫ ДУГААРЫГ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД МЭДЭГДЭНЭ.
3. ҮЦК-Д ЗАХИАЛГА ӨГЧ, ЗАХИАЛГЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАН, ТӨЛБӨРӨӨ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖ ДАХ ӨӨРИЙН НЭРИЙН ДАНСАНД ШИЛЖҮҮЛНЭ.
4. ҮЦК НЬ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ДЭЭР ЗГЖҮЦ-НЫ АРИЛЖААНД ОРОЛЦОНО

Шинэчлэл

Өөрийгөө зохицуулах байгууллага болсноор зах зээлд шинэ орчин бүрдэнэ

Монголын хөрөнгийн бирж нь 2015 оны аравдугаар сарын 13-нд өөрийгөө зохицуулах байгууллага болсон. Ингэснээр хөрөнгийн зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, зохицуулалтын зөв хандлагыг бий болгох, хяналт шалгалтын тогтолцоог бий болгох давуу талуудыг олгож байгаа юм. Жишээлбэл, хөрөнгө босгогчийн хувьд үнэт цаасны бүртгэлийн хяналт зохицуулалт (өмнө, хойно), үнэт цаас гаргагчдын мэдээллийн ил тод байдал, засаглалын хяналт, зах зээлд оролцогчид болон бүртгэлтэй компаниудад ижил тэгш хандан, олон нийт болон зах зээлд оролцогчдын итгэл үнэмшлийг хадгалах бол хөрөнгө оруулагчийн хувьд хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөв зохистой хяналтыг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагчдад зориулан үнэт цаасны зах зээлийн холбогдох мэдээллийг цаг алдалгүй ил тод болгох гэх мэт.

Мөн түүнчлэн хөрөнгийн биржийн үйл ажиллагааны ерөнхий журмуудад (Бүртгэлийн, Гишүүнчлэлийн болон Хяналт шалгалтын журам) өөрчлөлт оруулснаар үнэт цаас гаргах хугацааг багасгаж, хөрөнгө босгогчдод богино хугацаанд хямд өртгөөр хөрөнгө босгох, нөгөө талаас хөрөнгө оруулагчдын хувьд оруулсан хөрөнгөндөө хяналт тавих, мэдээллийг цаг тухайд нь авах боломжуудыг нээж өгч байгаа. Хувьцаат компаниудын хувьд хувьцааны I ангиллын шалгуурт өөрчлөлт оруулснаар тухайн ангилалд орох боломжийг нээж, компаниудын зах зээлд эзлэх байр суурийг олон нийтэд таниулахад дөхөм болсныг дурдах нь зүйтэй байх.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд нийт 15 компани 100 тэрбум төгрөгийг Хөрөнгийн зах зээлээс босгож урт хугацаат санхүүжилтийг татсан ба 2005 оны тавдугаар сарын 25-нд “Монгол шилтгээн” компани IPO хийж, олон нийтэд үнэт цаасаа санал болгож тухайн үеийн ханшаар 800 сая төгрөгийг босгосон билээ. Харин 2015 оны арванхоёрдугаар сард “МИК Холдинг” ХХК нэмэлт хувьцаа гаргасан бөгөөд үүний дүнд 19.5 тэрбум төгрөгийн хөрөнгө босгож чадсан нь бидний хувьд том амжилт байлаа. Шинэ оны босгон дээр “Монгол шуудан” ТӨХК төрийн мэдлийн хувьцааныхаа 34 хувийг нээлттэй зарах болсноо зарласан ба энэ нь хөрөнгийн биржээр арилжигдсан.

2016 онд хөрөнгийн бирж зах зээл дээрх бараа бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, зах зээлийн хүрээг тэлэх зорилгоор дорвитой арга хэмжээ авахаар ажиллаж байгаа бөгөөд Засгийн газрын үнэт цааснаас илүүтэй компанийн үнэт цаас руу анхаарлаа түлхүү хандуулах, мөн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх, идэвхжүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулах болно. Хөрөнгийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн системийг бий болгон түүнд суурилсан суурь судалгаануудыг хийж, зах зээл дээр ямар бүтээгдэхүүн хамгийн их хүлээлттэй байна, ямар чиглэлийн хөрөнгө оруулалтыг татаж болох, гаднын зах зээлээс Монголын хөрөнгийн зах зээлтэй шууд холбогдох боломжийг бий болгох зорилготой юм. Мөн энэ онд Монголын хөрөнгийн бирж 2.0 орчим их наяд төгрөгийн арилжаа хийх зорилго тавин ажиллаж байна. ■



Хөрөнгийн биржийн дүрэм журмын шинэчлэл

Гишүүнчлэлийн журмын шинэчлэлт

ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА БОЛОВСРУУЛАХ ШАЛТГААН

- Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолоор “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь өөрийгөө зохицуулах байгууллага болсонтой холбогдуулан СЗХ, Бирж, “ҮЦТТХТ” ХХК-ийн ажлын чиг, үүргийн хуваарилалт, уялдаа холбоог сайжруулах, хяналт шалгалтын үйл ажиллагааны давхардлыг арилгах,
- Гишүүдийн үйл ажиллагааг сайжруулах, зах зээлд чанартай үйлчилгээ үзүүлэхүйц ҮЦК-ийг зах зээлд ажиллуулах

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ


Одоогийн мөрдөж буй журам:

1.3. МХБ ТӨХК болон гишүүний харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг “Хамтран ажиллах гэрээ”-гээр зохицуулж ирсэн.

Журмын шинэчилсэн төсөл:

- 1.3. Бирж нь гишүүнээр элсэхээр өргөдөл гаргасан этгээдийн өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх, гишүүнд арилжаанд оролцохтой холбогдох үйлчилгээг үзүүлэх, хяналт тавих, хариуцлага ногдуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ нээлттэй, үл ялгаварлах зарчмыг баримтална.
- 3.2.1.2. Гишүүнээр элсүүлэх тухай Биржийн эрх бүхий этгээдийн шийдвэрийн дагуу өргөдөл гаргагч нь Гишүүнчлэлийн гэрээг Биржтэй байгуулсан.

ХОЁР. ГИШҮҮНЭЭР ЭЛСҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ



Журмын шинэчилсэн төсөл:

- Журам батлах, өөрчлөлт оруулах - ТУЗ шийдвэрлэнэ.
- Биржийн гишүүн ҮЦК-иар бүртгэх шийдвэр гаргах эрх бүхий этгээд Гүйцэтгэх захирал байна.

ГУРАВ: ГИШҮҮНЭЭР ЭЛСҮҮЛЭХ, ТАТГАЛЗАХ ТУХАЙ ШИЙДВЭР ГАРГАХ

Одоогийн мөрдөж буй журам:

Арилжаа, хяналтын алба

Материалын бүрдэлт, шалгуур хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийх;

Захирлын Зөвлөлийн хурал /ЗЗХ/

Өргөдөл гаргасан ҮЦК-ийн шалгалтын дүнг хэлэлцэн, ЗЗХ-ын гишүүдийн зүгээс бүртгэх эсэх санал гаргах;

ТУЗ ЗЗХ-ын гишүүдийн дэмжсэн саналыг үндэслэн бүртгэх эсэх тухай шийдвэр гаргана;

Шийдвэрлэх хугацаа Ажлын 20 хоног;

Журмын шинэчилсэн төсөл:

- Бүртгэлийн алба Материалын бүрдэлт, шалгуур хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийх;
- Гүйцэтгэх захирал Гишүүнчлэл хариуцсан нэгжийн дүгнэлтийг үндэслэн гишүүнээр элсүүлэх эсэх тухай шийдвэр гаргах;
- Шийдвэрлэх хугацаа Ажлын 15 хоног;

ДӨРӨВ: ТОГТМОЛ БИЕЛҮҮЛЭХ ҮҮРЭГ

Одоогийн мөрдөж буй журам:

- Тогтмол биелүүлэх үүрэг
- Хагас жил тутам Биржийн засаглалын үнэлгээний маягтын дагуу засаглалаа үнэлэх;
 - Гишүүнчлэлийн гэрээнд заасан үүргээ биелүүлж ажиллах;
 - Гишүүнчлэлтэй байх хугацаандаа холбогдох журам болон гэрээнд заасны дагуу жилийн үйлчилгээний хөлсийг заасан хугацаанд төлөх үүрэгтэй;

Журмын шинэчилсэн төсөл:

- Гишүүний үүрэг
- Хагас жил тутам Биржийн засаглалын үнэлгээний маягтын дагуу засаглалаа үнэлэх;
 - Гишүүнчлэлийн гэрээнд заасан үүргээ биелүүлж ажиллах;
 - Гишүүнчлэлтэй байх хугацаандаа холбогдох журам болон гэрээнд заасны дагуу жилийн үйлчилгээний хөлсийг заасан хугацаанд төлөх үүрэгтэй;
 - Хөрөнгийн хэмжээний гурваас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр үйл ажиллагааны эрсдлээс хамгаалах сан байгуулсан байх;
 - Харилцагчдын үнэт цаасны дансны талаарх мэдээллийг түргэн шуурхай гаргах автоматжуулсан дотоод бүртгэлийн системтэй байх
 - Мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах;

ТАВ: ХАРИУЦЛАГА

Гишүүн ҮЦК-д авах арга хэмжээ

Одоогийн мөрдөж буй журам:

- Гүйцэтгэх захирал
- Сануулах,
 - Торгууль ногдуулах,
 - Арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах,
- Төлөөлөн удирдах дэвлөл
- Гишүүнчлэлийн эрхийг түдгэлзүүлэх
 - Гишүүнчлэлээс хасах

Журмын шинэчилсэн төсөл:

- Гүйцэтгэх захирал
- Сануулах,
 - Торгууль ногдуулах,
 - Арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах,
 - Гишүүний эрхийг түдгэлзүүлэх,
 - Гишүүнээс хасах,

ЗУРГАА: ТӨЛБӨР ХУРААМЖ

Үйлчилгээний хөлсний төрөл	Тайлбар	Одоо мөрдөж буй журам	Журмын шинэчилсэн төсөл
Гишүүнээр элсэх өргөдлийг хянан шийдвэрлэх үйлчилгээний хөлс	Буцаан олгогдохгүй	500,000	500,000
Гишүүнчлэлийн элсэлтийн хөлс	Нэг удаа төлнө	15,000,000	15,000,000
Гишүүнээр элссэний дараа тогтмол төлөх үйлчилгээний хөлс			
Гишүүнчлэлийн хөлс	1 тусгай зөвшөөрөл бүхий этгээд	2,500,000	1,500,000
Гишүүнчлэлийн хөлс	2 ба түүнээс дээш тусгай зөвшөөрөл бүхий этгээд		2,000,000
Арилжааны системд нэвтрэх эрх ашигласны хөлс	Арилжааны системд нэвтрэх нэг эрх	195,000 /улиралд/	195,000 /улиралд/
Хөнгөлөлт / урамшуулал	Гишүүнчлэлийн төлбөрөөс 50 хүртэл хувиар хөнгөлөх	Нийт арилжааны үнийн дүнгийн 10 хувиас дээш	Нийт арилжааны үнийн дүнгийн 5 хувиас дээш

ДОЛОО: ҮР ДҮН

Гишүүнчлэлийн журмын шинэчилсэн төсөлд орсон өөрчлөлтүүд нь Биржээс авч хэрэгжүүлж буй хариуцлагын тогтолцоог сайжруулах, Гишүүдийн зах зээлд үзүүлэх үйлчилгээний төрөл, өнөөгийн санхүүгийн чадавч зэрэгт

нийцүүлэн гишүүнчлэлийн жилийн үйлчилгээний хөлсийг уян хатан зохицуулах, гишүүдийн эрх ашигт нийцсэн харилцааг бий болгох, түүнчлэн гишүүдийн арилжаанд оролцох идэвхийг нэмэгдүүлнэ гэж үзэж байна. ■

Бүртгэлийн журмын шинэчлэлт

ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА БОЛОВСРУУЛАХ ШАЛТГААН

Эрх зүйн зохицуулалт

- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49.1.2 заалт;

Шалтгаан

- Хороо болон Биржид үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой хийгдэх ажиллагааны давхардлыг арилгах, хоёр байгууллагын чиг үүргийг дахин хуваарилах;

- Үнэт цаасны бүртгэл болон бүртгэлд өөрчлөлт оруулахтай хугацаа, дарааллыг тодорхой болгох;
- Үнэт цаасны бүртгэлд орох өөрчлөлтийг ангилан тухай бүр хийгдэх ажиллагаа, нөхцөл, шаардлагыг тодорхой болгох. Үүнд:

- Өрийг хувьцаагаар солих зорилгоор нэмж үнэт цаас гаргах
- Компани нийлэх, тусгаарлах;
- Ажиллагсдад эзэмшүүлэхээр нэмж үнэт цаас гаргах;


НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Шинэчилсэн найруулга нь 10 бүлэг, 27 зүйлтэй.

- Журам нь Үнэт цаас гаргагчийн анх удаа болон нэмж гаргасан хувьцаа, өрийн хэрэгслийг Монголын Хөрөнгийн

Бирж ТӨХК-ийн үнэт цаасны бүртгэлд бүртгэх, бүртгэлийн ангилал, шалгуурыг тогтоох, үнэт цаасыг нийтэд танилцуулах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулна.

ХОЁР. ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ ЯВЦ



Журмын шинэчилсэн төсөл:

- Журам батлах, өөрчлөлт оруулах ТУЗ шийдвэрлэнэ
- Үнэт цаас гаргагч Гадаад болон дотоодын үнэт цаас гаргагч
- Бүртгэлийн процесс

ГУРАВ: ҮНЭТ ЦААС БҮРТГЭХ ЭСЭХ ШИЙДВЭР ГАРГАХ

Одоогийн мөрдөж буй журам:

Бүртгэлийн алба *Материалын бүрдэлт, шалгуур хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийх;*

Захирлын Зөвлөлийн хурал *Бүртгэлийн албаны шалгалтын дүнг хэлэлцэн, ЗЗХ-ын гишүүдийн зүгээс бүртгэх эсэх санал гаргах;*

ТУЗ *ЗЗХ-ын гишүүдийн саналыг үндэслэн бүртгэх эсэх тухай шийдвэр гаргана;*

Шийдвэрлэх хугацаа *Ажлын 20 хоног;*

Журмын шинэчилсэн төсөл:

Бүртгэлийн алба *Материалын бүрдэлт, шалгуур хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийх;*

Бүртгэлийн хороо *Бүртгэлийн албаны шалгалтын дүнг, хэлэлцэн, ЗЗХ-ын гишүүдийн зүгээс бүртгэх эсэх санал гаргах;*

Гүйцэтгэх захирал *Бүртгэлийн хорооны дүгнэлтийг үндэслэн бүртгэх эсэх тухай шийдвэр гаргаж Хороонд хүргүүлнэ;*

Шийдвэрлэх хугацаа *Ажлын 15 хоног;*

ДӨРӨВ: ТОГТМОЛ БИЕЛҮҮЛЭХ ҮҮРЭГ

Одоогийн мөрдөж буй журам:

Тогтмол биелүүлэх үүрэг

- Бүртгэлтэй байх хугацаанд тогтмол биелүүлэх үүрэг;
- Мэдээлэл ил тод болгох, үнэт цаас цаас гаргагчдын мэдээлэл түгээх заавар;

Журмын шинэчилсэн төсөл:

- Бүртгэлтэй байх хугацаанд журмын өрийн хэрэгслийн болон хувьцааны зохих ангиллын шалгуурыг хангаж ажиллах;
- Үнэт цаас хариуцсан ажилтантай байх;
- Хагас жил тутам Биржийн засаглалын үнэлгээний маягтын дагуу засаглалаа үнэлэх;
- Бүртгэлийн гэрээнд заасан үүргээ биелүүлж ажиллах;
- Мэдээлэл ил тод болгох;
- Үнэт цаас гаргагч нь бүртгэлтэй байх хугацаандаа холбогдох журам болон гэрээнд заасны дагуу жилийн үйлчилгээний хөлсийг заасан хугацаанд төлөх үүрэгтэй;

ТАВ: БҮРТГЭЛИЙН ШАЛГУУР

Одоогийн мөрдөж буй журам:

Анх бүртгүүлэх болон бүртгэлтэй байх хугацаандаа тухайн ангиллын шалгуурыг хангах шаардлагатай.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	I АНГИЛАЛ	II АНГИЛАЛ	III АНГИЛАЛ
Ашигт ажиллагаа	1 тэрбум төгрөгөөс доошгүй	Шаардлагатай эргэлтийн хөрөнгөтэй байх	-
Аудитлагдсан санхүүгийн тайлан	Сүүлийн 3 жил	Сүүлийн 2 жил	-
Компанийн засаглал	Дагаж мөрддөг байх	Дагаж мөрддөг байх үгүй бол тайлбар	-
Олон нийтэд санал болгон арилжих	25%-иас доошгүй	15%-иас доошгүй	-
Үйл ажиллагаа явуулсан жил	3-аас доошгүй жил	2-оос дээш	Эрх бүхий албан тушаалтан нь үйл ажиллагаа явуулах шаардлагатай туршлагатай байх
Андеррайтер	Заавал шаардах	Заавал шаардах	Заавал шаардах

Журмын шинэчилсэн төсөл:

Анх бүртгүүлэх болон бүртгэлтэй байх хугацаандаа тухайн ангиллын шалгуурыг хангах шаардлагатай.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	I АНГИЛАЛ	II АНГИЛАЛ	III АНГИЛАЛ
Ашигт ажиллагаа	500 сая төгрөгөөс доошгүй	Шаардлагатай эргэлтийн хөрөнгөтэй байх	-
Аудитлагдсан санхүүгийн тайлан	Сүүлийн 3 жил	Сүүлийн 2 жил	-
Компанийн засаглал	Дагаж мөрддөг байх	Дагаж мөрддөг байх үгүй бол тайлбар	-
Олон нийтэд санал болгон арилжих	25%-иас доошгүй	15%-иас доошгүй	-
Үйл ажиллагаа явуулсан жил	3-аас доошгүй жил	2-оос дээш	Эрх бүхий албан тушаалтан нь үйл ажиллагаа явуулах шаардлагатай туршлагатай байх
Андеррайтер	Заавал шаардах	Заавал шаардах	Заавал шаардах

ЗУРГАА: ТӨЛБӨР ХУРААМЖ

Одоогийн мөрдөж буй журам:

Хураамж	I ангилал	II ангилал	III ангилал
Өргөдлийн хүлээн авч хянах үйлчилгээний хөлс	Шинээр бүртгэхэд 2 000 000, нэмж бүртгэхэд 1 500 000	Шинээр бүртгэхэд 2 000 000, нэмж бүртгэхэд 1 500 000	Шинээр бүртгэхэд 2 000 000, нэмж бүртгэхэд 1 500 000
Үнэт цаас бүртгэх үйлчилгээний хөлс / 3ЗҮ-ний 0.1%/	Доод 10 сая Дээд 100 сая	Доод 5 сая Дээд 50 сая	Доод 1 сая Дээд 10 сая
Жилийн үйлчилгээний хөлс	Доод 1 200 000 Дээд 24 000 000	Доод 1 200 000 Дээд 24 000 000	500 000

Журмын шинэчилсэн төсөл:

Хураамж	I ангилал	II ангилал	III ангилал
Өргөдлийн хүлээн авч хянах үйлчилгээний хөлс	Шинээр бүртгэхэд 2 000 000, нэмж бүртгэхэд 1 500 000	Шинээр бүртгэхэд 2 000 000, нэмж бүртгэхэд 1 500 000	Шинээр бүртгэхэд 2 000 000, нэмж бүртгэхэд 1 500 000
Үнэт цаас бүртгэх үйлчилгээний хөлс /анхдагч зах зээлд арилжаалсан үнийн дүнгийн 0.1%/	Доод 10 сая Дээд 100 сая	Доод 5 сая Дээд 50 сая	Доод 1 сая Дээд 10 сая
Жилийн үйлчилгээний хөлс	Доод 1 200 000 Дээд 24 000 000	Доод 1 200 000 Дээд 24 000 000	500 000

ДОЛОО: ХҮРЭХ ҮР ДҮН

- Үнэт цаас гаргахтай холбоотой хугацаа тодорхой болох;
- Компани нэмж үнэт цаас гаргахад зардал хэмнэх;
- Процесс, процедурын хувьд тодорхой, ойлгомжтой болох, давхардал арилах;

- Хуулиар зохицуулагдсан боловч өргөн хэрэглэгддэггүй ногдол ашгийг хувьцаагаар олгох, давуу эрхийн хувьцаа гаргах, үнэт цаасыг зарлан бүртгүүлж шаардлагатай үед эргэлтэнд гаргадаг арга хэрэгслийг хөгжүүлэх замаар бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх;

НАЙН: НЭМЖ ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Үнэт цаас гаргагч нь Биржид хүсэлтээ түүрүүлж гаргах
- Бүртгэгдсэн үнэт цаасыг Хороонд хүргүүлэх;
- Үнэт цаасны танилцуулгыг Бирж бүртгэж Хороонд хүргүүлэх
- Бүртгүүлэх ажиллагааны бэлтгэл ;
- Хувьцаа, өрийн хэрэгслийг зарлан бүртгүүлж, шаардлагатай үед шат дараалан гаргах;
- Хувьцааны бүртгэлийн I ангиллын шалгуурт тухайн

- компанийн арилжигдсан үнийн дүнг нийт арилжаанд эзлэх хувиар тооцох ;
- Өрийн хэрэгсэл бүртгүүлэхэд санал болгож байгаа цар хүрээ, гаргаж буй этгээдийн онцлогоос хамаарч андеррайтер шаардахгүй байх;
- Хаалттай хүрээнд нэмж үнэт цаас гаргаж байгаа үед үнэт цаасны танилцуулга шаардахгүй байх; ■

Хяналт шалгалтын журмын шинэчлэлт

НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ШАЛТГААН

Эрх зүйн зохицуулалт

- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 49.1.5, 70.1.6, 70.1.9 дэх заалтууд

Шалтгаан

- Бирж нь ӨЗБ болсонтой холбогдуулан үндсэн чиглэлийн зарим журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага бий болсон. Энэ хүрээнд дараах өөрчлөлтүүд хяналт шалгалтын журамд орсон болно:
- Хяналт шалгалт хийх үндсэн чиглэлээс хэрэгжихгүй болсон зарим хэсгийг хасан, бусад журамтай уялдуулан шинэчилсэн.
- Хяналт шалгалтыг зохион байгуулах, хариуцлага ногдуулах эрхийг хяналт шалгалтын журамд цогцоор нь тусгах шаардлагын хүрээнд хууль журам зөрчин зөрчил гаргагчдад

газар дээр нь хариуцлага тооцох, арга хэмжээ авах эрх бүхий СЗХ той хамтарсан ажлын хэсгийг байгуулах талаар тусгасан.

- Биржийн Бүртгэлийн журам, Гишүүнчлэлийн журамд орсон өөрчлөлтийн дагуу зарим давхардлыг арилгах, чиг үүргийг хуваарилах, тодорхой болгох,
- Гишүүн үнэт цаасны компани, Үнэт цаас гаргагчид хийх зайны болон газар дээрх хяналт шалгалтын үйл ажиллагааны талаар зохицуулалт нэмж, өмнөх журамд орхигдсон зарим харилцааг бүрэн тусгаж, СЗХ-ны журмуудтай уялдуулан зарим заалт нэмэх, томъёолол, найруулгыг өөрчлөх,
- Өмнө мөрдөгдөж байсан журамд зөвхөн үнэт цаасны арилжаатай холбогдон гардаг зөрчлийг тусгасан байсанд нэмж үнэт цаас гаргагч болон гишүүн үнэт цаасны компанийн үйл ажиллагаатай холбоотой гарч болох зөрчлүүдийг тусгасан.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэмэлт өөрчлөлт нь 5 бүлэг, 13 зүйлтэй.

- Журам нь үнэт цаасны арилжаа, гишүүн үнэт цаасны компани, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулсан

хууль тогтоомж, журам, зааврын хэрэгжилт, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих, зохих шалгалтыг хийх, хариуцлага ногдуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛ

Үнэт цаасны арилжааны хяналт	Үнэт цаас гаргагчид тавих хяналт
Гишүүн ҮЦК-нд тавих хяналт	Өргөдөл, гомдол, мэдээ, мэдээлэлд үндэслэсэн хяналт

Түүнчлэн дээрх 4 чиглэлийн хүрээнд хийгдэх хяналт шалгалтын ажлуудыг нарийвчлан тусгасан. Тухайлбал: гишүүн ҮЦК нь гишүүнчлэлийн журмаар тогтоосон шалгуур шаардлагыг ханган

ажиллаж байгаа эсэх, Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаа, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт хариуцсан нэгж хяналт тавих гэх мэт.

ГУРАВ: ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ, ЭРХ ХЭМЖЭЭГ ТУСГАСАН

Хяналт шалгалтын мэргэжилтэн

- Хяналт шалгалтын 4 чиглэлийн хүрээнд хяналт шалгалтын үйл ажиллагааг өдөр тутам гүйцэтгэнэ.

Хяналт шалгалт хариуцсан нэгж

- Хяналт шалгалтын 4 чиглэлийн хүрээнд хяналт шалгалтын үйл ажиллагааг өдөр тутам гүйцэтгэнэ.
- Гишүүн үнэт цаасны компанийн үйл ажиллагаанд газар дээр нь гэнэтийн болон төлөвлөгөөт шалгалт хийнэ.

Хамтарсан ажлын хэсэг

- Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагч, хяналт шалгалтын мэргэжилтнээс бүрдэнэ.
- Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд газар дээр нь гэнэтийн болон төлөвлөгөөт шалгалт хийнэ.

ДӨРӨВ: ХАМТАРСАН АЖЛЫН ХЭСЭГ НЬ ДАРААХ ЭРХТЭЙ

Төлөвлөгөөт болон гэнэтийн шалгалтаар илэрсэн зөрчилд акт тогтоох, торгууль тавих;

Илэрсэн зөрчлийг арилгуулах талаар хугацаатай үүрэг, албан шаардлага өгч биелэлтийг хангуулах;

ТАВ: ЗӨРЧЛИЙН ТӨРЛҮҮД

- Үнэт цаасны арилжаатай холбогдох зөрчлүүд
- Гишүүн үнэт цаасны компанийн үйл ажиллагаатай холбогдох зөрчлүүд
- Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбогдох зөрчлүүд

ЗУРГАА: ХҮРЭХ ҮР ДҮН

- Үнэт цаас гаргагч болон гишүүн компаниудад тавих хяналт, шалгалт иж бүрэн болж хариуцлагын тогтолцоо тодорхой болох;
- Хяналт шалгалтын ажлын хэсгийн чиг үүрэг тодорхой болсноор үнэт цаас гаргагчдад хийх хяналт шалгалтын давхардал арилж үр дүн нэмэгдэнэ;
- Хуучин журмын үг найруулгыг засаж хоёрдмол утгагүй болгосноор үүссэн асуудлуудад маргаан үүсэх, хариуцлага зайлсхийх явдал арилна;
- Шалгалтаар авах арга хэмжээ нэмэгдсэнээр гишүүн болон бүртгэлтэй компаниудын дүрэм журам болон гэрээний үүргийн хэрэгжилт сайжирна
- Хаалттай хүрээнд нэмж үнэт цаас гаргаж байгаа үед үнэт цаасны танилцуулга шаардахгүй байх ■

“МИК Холдинг” ба IPO

Улаанбаатар хотын хүн ам дийлэнх хэсэг нь гэр хороололд амьдардаг, мөн сүүлийн 15 жилийн хугацаанд хотын хүн ам хурдацтай өсөхийн хажуугаар агаарын болон хөрсний бохирдол суурьшлын бус нутагт тулгамдсан асуудал болоод байгаа манай орны хувьд орон сууц нэн тулгамдсан асуудал болсон. Үүнийг дагаад орон сууцны барилгажилт ихээр нэмэгдэж, үүнтэй зэрэгцэн иргэдийн төлбөрийн чадавхид нийцсэн орон сууцны санхүүжилтийн тогтолцоог бий болгох, хөгжүүлэх шаардлага урган гарч ирсэн.

Манай улсад орон сууцны санхүүжилт буюу зээлийн үйлчилгээ 2003 оноос арилжааны банкуудын бүтээгдэхүүн болж эдүгээ зах зээлийн нийт багц 840 гаруй тэрбум төгрөгт хүрээд байна.


Орон сууц нь хүний амьдралын хамгийн гол хэрэгцээ болж байгын өсөн нэмэгдэх эрэлтийг дагуулж байдаг бол нөгөө талаас зээлийн харилцаанд оролцоходоо хөрвөх чадвар сайтай, найдвартай барьцаа болдог.

Энэ ч утгаараа эдийн засагт ялангуяа макро түвшинд томоохон байр суурь эзэлдэг. Ипотекийн анхдагч зах зээл нь зээлдүүлэгч санхүүгийн байгууллага болон зээлдэгч хоёрын хоорондын харилцаан дээр тулгуурлан үүссэн урт хугацаатай орон сууцны зээлүүд байдаг бол ипотекийн хоёрдогч зах гэхээр зах зээл дээр бий болсон байгаа ипотекийн зээлүүдийг тодорхой шинж чанар, нөхцөлөөр нь багцлан үнэт цаасжуулах замаар шинэ эх үүсвэрийг бий болгох үйл ажиллагаа юм. Ингэснээр урт хугацаагаар олгогдсон ипотекийн зээлүүд эргэлтэд орж шинэ эх үүсвэрийг бий болгох бөгөөд энэ нь орон сууцны эрэлт талыг буюу худалдан авахад чиглэгдсэн үйл ажиллагааг дэмжиж улмаар зээлийн хүү буурах, хугацаа уртсах зэрэг тааламжтай нөхцлүүдийг бий болгодог. Энэ нь зээлийн нөхцлийг хүчээр буюу зохиомлоор бус зах зээлийн өрсөлдөөний жамаар тааламжтай болгох нь хамгийн зөв зохицуулалт юм.


МИК нь гадаад, дотоодын хөрөнгийн зах зээл дээрх ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах замаар урт хугацааны зээлийн тогтолцоог бүрдүүлэх, хөрөнгө оруулалт санхүүжилтийн цогц үйл ажиллагааг шинээр шийдвэрлэхээр ажиллаж байна.

“МИК Холдинг” ХК нь арилжааны банкнаас иргэдэд олгосон орон сууцны найман хувийн зээлийг багцлан худалдан авч үнэт цаасжуулах, ипотекийн анхдагч болон хоёрдогч зах зээлийн хөрвөх чадварыг хангах, болон эрсдэлийг бууруулахаар үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд арилжааны банкууд 2.4 их наяд төгрөгийн орон сууцны зээлийг иргэдэд олгосон ба 74.8 мянган иргэдийг орон сууцжуулжээ. Үүнээс “МИК Холдинг” ХК нь 1.9 их наяд төгрөгийн зээлийн багцыг худалдан авч үнэт цаасжуулсан болно.


“МИК Холдинг” ХК нь сүүлийн гурван жилийн хугацаанд үйл ажиллагаагаа эрчимтэй өргөжүүлж, өөрийн хөрөнгөө 9.3 дахин, нийт хөрөнгөө 101.4 дахин өсгөж, 2014 оны байдлаар өөрийн хөрөнгийн өгөөжөө 26 хувьд хүргэн амжилттай ажилласан байна. Тус компанийн ирэх дөрвөн жилд өөрийн хөрөнгө болон өөрийн хөрөнгийн өгөөжийг доорх графикт харуулав. Өөрийн хөрөнгийн өгөөж нь тухайн байгууллагын нэгж өөрийн хөрөнгөд ногдох ашгийн хэмжээг илэрхийлдэг ба МИК-ийн хувьд энэ үзүүлэлт нь байнга өсөлттэй байгаа ба цаашид нэгж хувьцаанаас олох орлого нэмэгдэх, мөн үйл ажиллагаагаа өргөтгөх боломжийг харуулж байгаа юм.



“МИК Холдинг” ХК-ийн дараагийн дөрвөн жилд гаргах хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хэмжээ (тэрбум төгрөг)



Компаниудын хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ (тэрбум төгрөг)




Мөн тус компани нь хөрөнгийн зах зээлд үнэт цаасаа нээлттэй арилжаалсан нь барилгын салбарын болон бусад салбарт ажиллаж үйл ажиллагаагаа явуулж буй компаниудын хувьд хөрөнгийн зах зээлээс хямд өртөгтэй хөрөнгө оруулалтыг босгож болдог гэдгийн нэг жишээ болж байгаа юм.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд нийт 15 компани 78.2 тэрбум төгрөгийг Хөрөнгийн зах зээлээс босгож урт хугацаат санхүүжилтийг татсан ба 2005 оны тавдугаар сарын 25-нд “Монгол шилтгэн” компани IPO хийж, олон нийтэд үнэт цаасаа санал болгож тухай үеийн ханшаар 800 сая төгрөгийг босгосон билээ.


2015 онд БиДиСек, “Бинсэ”, “Эрчим Инжинеринг”, МИК холдинг зэрэг компаниуд нэмэлт хувьцаа, компанийн бонд болон IPO хийж Хөрөнгийн зах зээлээс урт болон богино хугацаат хямд, өртөг багатай санхүүжилтийг татаж бизнесээ өргөжүүллээ. Цаашид бүхий л салбарын компаниудад хөрөнгийн зах зээлийн үүд хаалга үргэлж нээлттэй байх ба энэ нь Монголын хөрөнгийн биржийн өмнөө тавьсан зорилтуудын нэг юм. ■

“Монгол шуудан” ба IPO

94 жилийн түүхтэй “Монгол шуудан” компани нь Монголын шуудангийн зах зээлийн 95 хувийг, олон улсын буухиа шуудангийн зах зээлийн 30 хувийг эзэлж байна. Монгол Улсын 21 аймаг, 334 сумдын салбар, Улаанбаатар хотын 40 салбар, 895 ажилтан албан хаагчтай. Шуудангийн 20 нэр төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн явуулдаг. Мөн дэлхийн 200 улстай, түүний дотор шуудангийн хамгийн шуурхай хэлбэр буюу буухиа шууданг эрэлт ихтэй байдаг 36 оронтой солилцож, 40 мянга гаруй үйлчлүүлэгч хэрэглэгчийн болон орцны шуудангийн хайрцагар дамжуулан үйлчилгээ үзүүлдэг.



Тус компани нь захидал, бичиг, боодол илгээлт зэрэг шуудангийн үйлчилгээ, шуудангийн марк, үнэт цаасны эх зураг хийх, гадаад дотоодын тогтмол хэвлэлийн захиалга авах, хүргэх, борлуулах үүнтэй холбогдон үүсэх ажил үйлчилгээг үзүүлдэг.



Өнгөрсөн таван жилийн хугацаанд компанийн хөрөнгийн хэмжээ жилд дунджаар 15.5 хувиар өсч 16 тэрбум 150 сая төгрөгт хүрчээ. Түүнчлэн эздийн өмчийн хэмжээ жилд дунджаар 20.5 хувиар өсч 14 тэрбумд хүрээд байна. Банкны зээлгүй учраас санхүүгийн эрсдэл маш багатай. Үүний зэрэгцээ борлуулалтын хэмжээ өнгөрсөн таван жилийн хугацаанд жилд дунджаар 15.28 хувиар өсч 11 тэрбум төгрөгт хүрсэн бол 2014 онд 738 сая төгрөгийн ашигтай ажилласан. Мөн сүүлийн таван жилийн турш тасралтгүй ашигтай ажилласан.

Компанийн хөрөнгийн хэмжээ тасралтгүй өсч байгаа нь үйл ажиллагааны цар хүрээ тэлсээр байгааг илтгэж байна.

Нөгөө талдаа эдгээр хөрөнгийг эздийн өмчийн эх үүсвэрээр санхүүжүүлж өр төлбөр, зээлийн дарамт компанид үүсэхгүй байгаа нь хямралын үед компанийн санхүүгийн ачааллыг бууруулж буй таатай нөхцөл байдал юм. Харин орлогын хувьд тогтмол өсөлттэй байгаа нь шинээр бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлж зах зээлээ тэлсэнтэй холбоотой. Үүний үр дүнд компани жил бүр ашигтай ажиллаж байгаа нь компанийн санхүүгийн чадавхи сайжрах боломжийг олгож байна.

“Монгол шуудан” нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх, зах зээлд шинэ бүтээгдэхүүн гаргах, ард иргэддээ хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх үүднээс “Авто замын логистикийн үйлчилгээ” төслийг хэрэгжүүлэх гэж байгаа билээ.

Монголын хөрөнгийн бирж нь “Монгол шуудан” компанийн андеррайтер болох “Гаули УЦК” компанитай хамтарч ажилласны үр дүнд анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2015 оны арванхоёрдугаар сарын 28-наас энэ оны нэгдүгээр сарын 06-ны хооронд явуулж нийт 68,134,427 ширхэг хувьцаа худалдан авах захиалга бүртгэсэн нь санал болгож буй нийт хувьцаанаас 101 хувь их байлаа. Энэ нь хөрөнгийн зах зээл сэргэж байгааг, цаашдаа хөгжих боломж байгааг, мөн бүтээгдэхүүний эрэлт их байгааг, дотоодын хөрөнгө оруулагч нар идэвхтэй байгааг харуулж байна.

Хөрөнгийн биржээр дамжуулан энэхүү өмч хувьчлалуудыг хэрэгжүүлэх ач холбогдол нь хөрөнгийн зах зээлд олон улсын жишигт нийцсэн хувьцаат компани бий болж хөрөнгийн захад итгэх итгэл нэмэгдэх, чанартай сайн бүтээгдэхүүн бий болж иргэд хөрөнгө оруулж өгөөж хүртэх, өмч хувьчлалын процесс ил тод, шударга хэрэгжиж бодит үнэлгээндээ хүрч үнэ цэнэ өсөх юм. Харин компанийн түвшинд засаглал нь илүү оновчтой болж санхүүгийн гүйцэтгэл улам сайжрах, санхүүгийн чадавхи сайжирахын хэрээр ажилчдын цалин хөлс, урамшуулал нэмэгдэх эерэг нөлөөтэй юм.



Хөрөнгийн биржийн удирдлага цаашдаа хөрөнгийн зах зээлийг идэвхжүүлэх, шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах, хөрөнгийн зах зээлд итгэх итгэлийг буцаан сэргээх талаар томоохон бодлогын арга хэмжээг шат дараалан авах болно.

Хөрөнгө оруулагчиддаа нэмж хэлэхэд хямралын үед хөрөнгө оруулах нь хамгийн ашигтай байдаг. Учир нь энэ үед хувьцааны үнэ бодит үнэлгээнээсээ буурсан байдаг бөгөөд эргээд эдийн засаг сэргэх үед үнэ өндөр хувиар өсч хөрөнгө оруулагчид өгөөжөө хүртдэг. Харамсалтай нь хүн бүрт хангалттай хэмжээний хөрөнгө оруулалт хийх боломж хямралын үед байдаггүй нь ашигтай хувьцаа худалдан авах боломжоо алдахад хүргэдэг нь тоогүй. ■

Хууль

Т.Гандулам: Бүтээгдэхүүн чухал ч худалдан авагчдыг бэлтгэх хэрэгтэй

Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны зохицуулалтын газрын дарга Т.Гандуламтай хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орчин болон үнэт цаасны зах зээлийн талаар ярилцлаа.

-Монголд хөрөнгийн бирж байгуулагдаад 25 жил болж байна. Энэ хугацаанд санхүүгийн зах зээлийн хууль эрх зүйн зохицуулалт хэр боловсронгуй болсон бэ?

Монголын хөрөнгийн бирж 1991 онд үүсгэн байгуулагдсан. Энэ үеэс хөрөнгийн зах зээлийг зохицуулахтай холбоотой төр засгийн бодлого, шийдвэрүүд гарч холбогдох эрх зүйн зохицуулалт хийгдэж ирсэн. 25 жилийн хугацаанд “Үнэт цаасны зах зээлийн тухай” хууль хоёр удаа шинэчлэгдэн батлагдсан. Хамгийн сүүлд 2013 оны тавдугаар сарын 24-ны өдөр УИХ-аар батлагдсан бөгөөд 2014 оны нэгдүгээр сарын 1-нээс эхлэн хууль хүчин төгөлдөр үйлчилж байна.

Анх хөрөнгийн биржийг байгуулж байх үед мөрдөгдөж байсан хууль эрх зүйн зохицуулалтыг өнгөрсөн 25 жилийн хугацаанд дэлхий нийтийн глобалчлал, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ болон зах зээлийн дэд бүтцийг олон улсын жишигт нийцүүлэх зэрэг цаг үеийн шаардлагын дагуу нийцүүлэн шинэчлэх зайлшгүй шаардлагатай болсон. Тиймээс, олон улсын жишигт нийцсэн, гадаад болон дотоод хөрөнгө оруулалтыг татах боломж бүхий хууль эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх үүднээс хөгжиж буй болон хөгжсөн орнуудын үнэт цаасны зах зээлийг зохицуулж буй эрх зүйн орчныг судалж, улмаар Монголын хөрсөнд буусан хуулийн төслийг боловсруулах ажлыг үнэт цаасны зэх зээлд оролцогч мэргэжлийн бүх байгууллагатай хамтран боловсруулж, батлуулж байсан түүхтэй.

-Хоёр жилийн өмнөөс хэрэгжиж байгаа Үнэт цаасны зах зээлийн тухай шинэчлэн батлагдсан хуулийн онцлогийн талаар танаас сонирхоё.

-Хөрөнгийн зах зээлд тулгамдсан асуудал дэд бүтэц байсан. Тус хуулиар хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн



байгууллагын зохицуулалтыг илүү тодорхой болгосон. Хоёрдугаарт, олон шинэ харилцааг бий болгосон. Тухайлбал, бүтээгдэхүүн талаасаа Монголын хөрөнгийн бирж болон гадаадын хөрөнгийн бирж дээр үнэт цаасыг давхар бүртгүүлэх, хадгаламжийн бичиг гаргах, мөн өөрийгөө зохицуулах байгууллага болон кастодиан банкны үйлчилгээ, түүний зохицуулалт зэргийг нарийвчлан тусгаснаараа онцлогтой. Хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос өөрийгөө зохицуулах байгууллагаар хоёр байгууллагыг бүртгэлээ. Энэ бол Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Монголын хөрөнгийн бирж хоёр юм.

-Өөрийгөө зохицуулах байгууллага болсноор ямар өөрчлөлт шинэчлэлт бий болох вэ?

-Өөрийгөө зохицуулах байгууллага ямар ач холбогдолтой вэ гэхээр олон улсын жишгийн дагуу гишүүнчлэлтэй байгууллага бөгөөд гишүүдийнхээ ёс зүйн хэм хэмжээ, үүрэг хариуцлагыг өөрөө тогтооно. Үнэт цаасны зах зээл дээр аливаа хууль бус үйлдэл болох үнэ ханшийг зохиомлоор өсгөх эсвэл бууруулах, зах зээлийг урвуулан ашиглах гэх мэт үйлдлийг гишүүдээсээ гаргуулахгүй байх, ёс зүйтэй, шударга

өрсөлдөөнт орчныг бүрдүүлэхэд анхаарч, шаардлагатай тохиолдолд зохицуулагч байгууллагатай хамтран хяналт шалгалт хийх, аливаа хууль бус үйлдлийг таслан зогсоох чиглэлээр төрийн байгууллагатай хамтран ажиллах, гишүүдээ мэргэшүүлэх сургалтад хамруулах, давтан сургах зэрэг өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулах мэргэжлийн байгууллага болох юм. Ингэснээрээ үнэт цаасны зах зээлийг шударга, нээлттэй, ил тод болгоход чухал үүрэг гүйцэтгэх ба гишүүд нь ёс зүйтэй, мэргэшсэн болж төлөвшинө. Мөн зарим төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх юм. Үүнд, өмнө нь хороо зуучлагч байгууллагад тусгай зөвшөөрөл олгосноор холбооны гишүүнээр элдэг байсан бол өнөөдөр эсрэгээрээ өөрийгөө зохицуулах байгууллагын шаардлагыг хангаагүй тохиолдолд тухайн байгууллагын хүсэлтээр тусгай зөвшөөрлийг нь хороо цуцлах юм.

Мөн Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс өөрийгөө зохицуулах байгууллагыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, гишүүдийг нь сургах чиглэлээр Монголын арилжаа эрхлэгчдийн холбоотой хамтран ажиллах санамж бичгийг өнгөрсөн оны аравдугаар сард байгуулсан. Санамж бичгийн хүрээнд гурван жилийн хамтран ажиллах төлөвлөгөөгөө хамтран баталсан. Жил бүр төлөвлөгөөгөө тодотгон баталж, улмаар гүйцэтгэлийг жилд хоёр удаа дүгнэн тайлагнаж ажиллана. Нэгдсэн нэг санаа бодолтой, хийх ажлаа төлөвлөж, нэг зорилго дор хамтран ажиллах юм бол зах зээлд оролцогчдод хүндрэлгүй байх болно.

-Мэргэжлийн хөрөнгө оруулагчид буюу институциональ хөрөнгө оруулагчдыг бий болгох шаардлага байгаа. Энэ чиглэлээр хууль эрх зүйн хүрээнд ямар шинэлэг зохицуулалтууд байгаа вэ?

-Тиймээ, эрх зүйн зохицуулалтын шинэчлэлийн бас нэг асуудал нь институциональ буюу мэргэжлийн хөрөнгө оруулагчтай холбоотой юм. Тухайлбал, хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани, ▶

▶ эдгээрт үйлчилгээ үзүүлэх кастодиан банк гэсэн цоо шинэ харилцааг шинэчилэн баталсан хуулиар зохицуулсан. Ямар этгээд ямар шаардлага хангаснаар эдгээр үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл авахыг нарийвчлан тусгасан.

Хөрөнгийн биржид худалдах чанартай бүтээгдэхүүн чухал боловч нөгөө талдаа тэрхүү бүтээгдэхүүнийг худалдан авах худалдан авагчийг бий болгох шаардлагатай. Худалдагч, худалдан авагч хоёулаа байж гэмээнэ үнэт цаасны зах хөгжинө. Бид баахан бүтээгдэхүүн гаргаад байдаг худалдан авагч байхгүй цагт энэ зах хөгжих боломжгүй. Бүтээгдэхүүний хөрвөх чадварыг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай. Худалдан авагчийн хувьд хөрөнгийн зах зээл дээр нэг онцлог байдаг. Ихэнх хөгжсөн орны хувьд үнэт цаасны зах зээлийн гол тоглогч нь мэргэжлийн буюу институциональ хөрөнгө оруулагч нар байдаг. Эдгээр хөрөнгө оруулагчид зах зээл дээр маш том худалдан авагч болдог. Тиймээс бидний хувьд анхаарал хандуулж буй өөр нэг зүйл нь мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох, өсгөн бойжуулах асуудал юм.

Өнгөрсөн онд Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс “Хөрөнгө оруулалтын сангийн болон Кастодианы санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтөлх, цэвэр хөрөнгийг үнэлэх” зааврыг шинээр боловсруулж, Монголбанк болон Сангийн яамтай хамтран баталж, энэ оны нэгдүгээр сарын нэгнээс мөрдөж байна. Ингэснээр тухайн байгууллагын үйл ажиллагааны эрсдлийг бууруулах, хөрөнгө оруулагчдын зүгээс тэдэнд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, нягтлан бодох бүртгэл нь олон улсын стандартад нийцэх зэрэг ач холбогдолтой.

-Өнөөдрийн байдлаар хорооноос Хөрөнгө оруулалтын сан болон Кастодианы үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан хэчнээн байгууллага байна вэ?

Өнөөдрийн байдлаар долоон хөрөнгө оруулалтын менежментийн компани, хувийн хөрөнгө оруулалтын сан хоёр, кастодиан гурван банк Хорооноос тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. Мөн хамтын хөрөнгө оруулалтын сан байгуулах тухай нэг хүсэл тирсэн.

-Зах зээлд оролцогчид хохирдоггүй байх, чанартай бараа бүтээгдэхүүнтэй байх, эрсдэлгүй байх боломж хэрхэн хангагдаж байгаа вэ?

-Энэ бол маш чухал асуудал. Манай хорооны зүгээс авч хэрэгжүүлж байгаа бодлогын арга хэмжээний нэг хэсэг нь арилжаалагдаж буй бараа бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, чанаргүй бараа бүтээгдэхүүн гаргахаас сэргийлэхэд оршино. Үүний хүрээнд хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталлаа. Мөн Монголын хөрөнгийн биржийн бүртгэлийн журам шинэчлэгдсэн. Эдгээр журмуудыг олон улсын түвшинд нийцүүлэх ажлууд хийгдлээ.

-Шинэчлэгдсэн журмын өмнөхөөс ялгарах гол онцлог юу байгаа вэ та цухас дурдахгүй юу?

-Бүртгэлийн журмын гол ач холбогдол нь юу вэ гэхээр арилжаалж байгаа бараа бүтээгдэхүүнийхээ чанарыг сайжруулах үүднээс үнэт цаасны ангилал тус бүрийн шаардлагыг шинэчлэн, шалгуур үзүүлэлтийг ангилал тус бүрээр тогтоосон. Биржийн зүгээс лангуунд байгаа барааныхаа чанарт нь хяналт тавьдаг байх зохицуулалтыг тусгасан. Мөн хороо болон биржийн хяналтын давхардлыг арилгаж өгсөн. Нөгөөтэйгээр өмнөх журмаас ялгарах өөр нэг зүйл нь цаг хугацааны хувьд маш богиноссон. Тухайн үнэт цаас гаргаж байгаа компанийг хороо болон биржид бүртгэх үйл явц өмнө нь 40 хоногоос 3 сарын хугацаатай үргэлжилдэг байсан бол одоогийн шинэ журмаар Хөрөнгийн бирж болон хороонд IPO гаргах хүсэлтээ хамт ирүүлнэ. Хөрөнгийн бирж шалгаад бүртгэх эсэх дүгнэлтээ хороонд ирүүлнэ. Хороо хөрөнгийн биржийн бүртгэх зөвшөөрөл олгоё гэсэн дүгнэлтийг үндэслэж, шийдвэрээ гаргадаг болсон. Цаг хугацааны хувьд ажлын 15 хоногт бүртгэх зөвшөөрөл олгох асуудал шийдвэрлэгдэнэ. Энэ бол хөрөнгө оруулалт татах сонирхолтой компаниудын хувьд олон талын ач холбогдолтой.

Хөрөнгийн бирж өөрийгөө зохицуулах байгууллага болсноор өөрсдийн дүрэм, журам болон гишүүнчлэлдээ тавих шаардлага, шалгуураа тогтоох, тэдгээрт тавих хяналтын механизмсаа сайжруулах зэрэг эрх, үүрэг, хариуцлага нь нэмэгдсэн. Нөгөө талаас энэ нь төр, хувийн хэвшлийн зохистой түншлэлийн харилцааг бүрдүүлж өгнө.

-2016 онд хорооны зүгээс салбартаа ямар ажлууд хийхээр байгаа вэ?

-Манайх зохицуулагч байгууллагын хувьд 2016 оны үйл ажиллагаа гэхээсээ илүү ойрын 10 жилийн хугацааны салбарын хөгжлийн хөтөлбөрийг Мон-

голбанк, Сангийн яамтай хамтран боловсруулсан. Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн стратеги гэсэн хөтөлбөрийг гаргасан. Энэ маань нэг нэг жилийг харсан биш, арван жилийн хугацаанд тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхтэй холбоотой макро түвшинд хийгдэх ажлуудыг санхүүгийн зохицуулалтын байгууллагууд болон холбогдох төрийн байгууллага ийм ийм хугацаанд хийж, хэрэгжүүлнэ гэж тусгасан. Тухайлбал, зах зээл рүү чиглэсэн бодлого нь бид бүтээгдэхүүн гаргаад, хөрөнгө оруулагч бэлдэхээсээ илүүтэй тэднийг хөрөнгийн зах зээлд татан оролцуулах эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэхэд анхаарах ёстой. Хөгжсөн оронд хаалттай компани болон хувьцаат компанийн хооронд асар их ялгаа байдаг. Хувьцаат компаниудыг төрийн зүгээс бодлогоор дэмжиж, давуу эрх олгодог. Тэгэхээр нээлттэй компани болохыг дэмжих төрийн бодлого, зохицуулалт зайлшгүй шаардлагатай байна. Ялангуяа эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх үүднээс хувьцаа борлуулсаны орлогыг татвараас чөлөөлөх, хувь хүний болон аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх саналууд энэ хөтөлбөрт тусгагдсан. Энэ хөтөлбөр батлагдсан тохиолдолд зах зээл дээр нэлээд томоохон эерэг өөрчлөлтийг авчирна гэж үзэж байна.

2016 оны хувьд бүтээгдэхүүн талаас зөвхөн бонд болон хувьцааны зах зээл гэхээс гадна үүсмэл үнэт цаасны зах зээлийг бий болгох ажлыг энэ онд хийхээр төлөвлөсөн. Үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгэх эрх зүйн орчныг бүрдүүлэх тал дээр холбогдох судалгааны ажлыг эхлүүлсэн.

-Хувьцаа болон бондын зах зээлд ямар шинэ хандлага байна вэ?

Өнгөрсөн онд хөрөнгийн зах зээл үүсч хөгжсөнөөс хойших 25 жилийн түүхэнд хийгдээгүй үнийн дүн бүхий арилжаа явагдсан. Нийт 546,4 тэрбум төгрөгийн арилжаа. Хамгийн гол нь Монгол Улсын Засгийн газрын 510 тэрбум төгрөгийн бонд арилжигдлаа. 2011 онд 241 тэрбум төгрөгийн бонд арилжиж, нийт 350,2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хамгийн их арилжаа хийгдсэн жил байсан юм. Засгийн газрын бондыг Хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалж болдог юм байна, олон нийт энэ бондыг сонирхож худалдан авах боломж байгаа юм байна гэдгийг харууллаа. Статистикаас харахад эдийн засгийн ▶

► байдал таагүй байна гэж байгаа боловч манай зах зээл дээр харин ч эсрэгээрээ их гүйлгээ хийгдсэн байна. Жишээ нь, 2015 онд 6,3 их наяд төгрөгийн үнэт цаасны төлбөр тооцооны гүйлгээ хийгдсэн. Тэгэхээр бид боломж байна, иргэд зөвхөн банк дээр хадгаламж эзэмшигч байхаасаа илүүтэй бонд авч, хувьцаанд хөрөнгө оруулалт хийж үр өгөөжийг өөр хэлбэрээр олж болдог юм байна гэдгийн тод жишээ. 2016 онд илүү олон чанартай бүтээгдэхүүн гараасай гэж хүсч байгаа. Хорооны зүгээс бодлогын хувьд энэ зах зээлийн эрсдэлийг багасгаж, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх хүрээнд даатгалд хамруулах, нөгөө талаар даатгалын салбарыг хөрөнгийн зах зээл рүү оруулах боломжийг судалсан. Сүүлийн 7-8 жилд компанийн бондын

арилжаа зогссон байсан бол 2015 онд “Эрчим бонд” гээд анх удаа зах зээлд дээр даатгагдсан бондыг арилжаалсан. Ингэснээрээ хөрөнгө оруулагчдыг эрсдэлээ хамгаалах том хөшүүрэг болсон.

-Кастодиан банкны үйл ажиллагаа энэ онд хэр жигдрэх бол.

-Мэргэшсэн хөрөнгө оруулагчдад зориулсан үйлчилгээ үзүүлдэг кастодианы тусгай зөвшөөрлийг ХААН, ХХБ, Голомт гурав авсан. Энэ үйлчилгээ 2016 онд нэлээд жигдрэнэ гэж бодож байгаа. Ингэснээр гадны мэргэжлийн хөрөнгө оруулагчид орж ирэх боломж бололцоо нээгдэх юм. Мөн зөвхөн Монголд арилжаанд оролцохоос гадна Монголд байгаа үнэт цаасыг гадаадын хөрөнгийн бирж дээр хадгаламжийн бичиг болгон гаргах боломжтой болно. ■

бүтнээр нь болон хэсэгчлэн стратегийн хөрөнгө оруулагчдад дуудлага худалдаагаар зарах болон /Share issue privatization (SIP)/ хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалах гэсэн үндсэн гурван аргыг ашигладаг байна. Эдгээр аргуудыг ашиглах сонголт нь тухайн улсын улс төрийн бодлого, дотоодын зах зээлийн орчин болон хувьчлагдах байгууллагын онцлог, хэмжээнээс голчлон хамаардаг.

1990-ээд оноос өмнө Их Британи, Герман, Франц, Итали, Шинэ Зеланд, Мексик, Канад, Австрали, Польш, Чех, Унгар зэрэг улс томоохон хэмжээний хувьчлалын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн байдаг. Ингэхдээ олон нийтэд хувьцаа санал болгон арилжаалах (Public Offering) аргыг илүү түгээмэл буюу нийт аргын 62 хувьд нь ашигласан байдаг. /график 1/ Ялангуяа Их Британи, Герман, Итали, Франц зэрэг орнуудын төрийн өмчийн хувьчлал нь дотоодын хөрөнгийн зах зээлийнхээ хөгжлийг дэмжих гол зорилготой байсан. Харин Австрали, Мексик болон хуучны социалист орнууд, жишээ нь Польш, Унгар, Чех зэрэг оронд дараагийн нэг түгээмэл ашигласан арга нь дуудлага худалдаагаар (Trade Sale) буюу тендер саналаар худалдах арга байсан байна.

Дуудлага худалдаагаар (Trade Sale) буюу тендер саналаар худалдаалах болсон шалтгаан нь: Хувьчлах компани нь хөрөнгө багатай, санхүү болон хуулийн дэд бүтэц муу, зах зээлийн эдийн засагт хурдан шилжих зэрэг хүчин зүйлүүд нөлөөлсөнд оршино. (график 1)



Франц улсын туршлага

Франц улс нь төрийн өмчийн удирдлага, түүнд нөлөөлөх улс төрийн оролцоо, хувьчлалын туршлага арвинтай улс юм. Тус улсад төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэгч агентлаг 2004 онд байгуулагдан эдийн засаг дахь төрийн оролцоо, төрийн өмчийн

Төрийн өмчийн хувьчлал

Төрийн өмчийг Хөрөнгийн биржээр дамжуулан хувьчлахын ач холбогдол

Ж.МЯГМАРСҮРЭН

(МХБ-ийн Маркетинг, олон нийттэй харилцах албаны захирал)

Дэлхий дахинд төрийн оролцоотой компаниудын төрөл олон янз байгаа хэдий ч төрийн хувьд үр ашигтай удирдлага, өгөөж бий болгох, эдийн засгийн хөгжлийг дэмжих зэрэг стратегийг хэрэгжүүлэх зорилгоор төр хувьцаа эзэмшигч болох ерөнхий чиг хандлага давамгайлж байна.

Монгол дахь төрийн өмчийн хувьчлал

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжин нийт иргэдэд хөрөнгө оруулалтын эрхийн бичиг олгох замаар улсын үйлдвэрийн 475ХК-ийг хувьчилсан. Энэхүү хувьчлалаар иргэд, олон нийтэд гарааны ижил нөхцлийг санал болгосон ч дийлэнх иргэдийн бэлтгэл сайтар хангагдаагүй, мэдлэг, мэдээлэл дутмаг байсан тул хаяж үрэгдүүлэх, туршлагатай гэх цөөн хүмүүст хямд үнээр хувьцаагаа зарах зэргээр урт хугацааны үр өгөөжийг хүртэж чадалгүй алдсан байдаг.

1995 онд үнэт цаасны хоёрдогч зах зээл амжилттай нээгдэж, 2005 оноос эхлэн хөрөнгийн зах зээлийг сонгодог

утгаар хөгжүүлэх зорилт тавьсанаар олон нийтэд хувьцаа санал болгож нээлттэй хувьцаат компани байгуулах ажлыг эрчимтэй явуулж ирсэний үр дүнд нийт 11 компани шинээр үнэт цаас гаргах замаар 24,9 тэрбум, найман компани нэмж үнэт цаас гаргах замаар 26,5 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлж чадсан байна.

Одоогийн байдлаар Монголын хөрөнгийн биржид 100 хувь төрийн өмчит 21, төрийн өмчийн оролцоотой 17 компани бүртгэлтэй байна.

Олон улсын туршлага

Дэлхийн улс орнууд төрийн өмчит хуулийн этгээдүүдийг хувьчлах замаар Засгийн газрын төсвийн орлогыг нэмэгдүүлэх, эдийн засгийн хөгжилд түлхэц үзүүлэх туршлагыг эртнээс хуримтлуулж ирсэн. Үүний нэг томоохон давалгаа 1990-ээд оноос социалист улс орнууд таран бутарсан үед эрчимтэй явагдсан байдаг.

Олон улсад төрийн өмчит хуулийн этгээдүүдийг хувьчлахдаа /Voucher/ хөрөнгө оруулалтын эрхийн бичиг тараах замаар бүх иргэдэд үнэ төлбөргүй, эсвэл маш бага үнээр хувьчлах, /Trade Sale/



үр ашигтай удирдлагын стратеги боловсруулан амжилттай хэрэгжүүлж байна. Франц улсын хувьчлалын хандлагад зарим онцлог сонирхолтой боломжууд ажиглагддаг. Төрийн өмчийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ төр хувьцаа эзэмшигч хэлбэрээр оролцдог бөгөөд 1984 оноос 2012 он хүртэлх Франц улсын нийт өмч хувьчлалын орлого болон хэлцлээс харахад олон нийтэд хувьцаа санал болгох (Public Offering) аргыг түгээмэл ашигласан нь ажиглагддаг. / график 2/ Тэр дундаа хэсэгчлэн хувьчлах хэлбэрээр гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татаж төрийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлсэн байдаг. Хэсэгчлэн хувьчлахдаа 5-10 хувийг анхлан олон нийтэд санал болгосноор зардал бага зарцуулж, олсон орлогоор дараагийн хэсгийг хувьчлах зардлыг нөхөх, хувьцааны үнийг өсгөх чухал ач холбогдолтой байдаг. Энэ арга нь тухайн компанийг бүрэн хувьчлах, эсвэл төрд хяналтын багцыг үлдээх аль алинд нь тохирсон байдаг. Жишээ нь: “Cie des Machines Bull” компанийг 1995, 1997, 2005 онд хэсэгчлэн бүрэн хувьчилсан бөгөөд “Air France” компанийг 1999 он болон 2004 онд хувьчлан төрийн мэдэлд 15.70 хувь байдаг бол “Aerospatiale Matra” компанийг 1988, 1999, 2001 онуудад хувьчлан төрийн мэдэлд 0,60 хувь нь үлдсэн байдаг байна. Хувьчлагдсан компанийн маш бага хувиар төрийн хяналт удирдлагыг хэрэгжүүлж болдогийг дээрх жишээнээс харж болох юм. (график 2)

Монгол Улс

УИХ-н 2015 оны 70 дугаар тогтоолоор “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийг баталж, хуулийн этгээдийг хувьчлах, өөрчлөн зохион байгуулах ажлыг хийхийг Засгийн газарт даалгасан.

Тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “2015-2016 онд хувьчлах, өөрчлөн

байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт”-ыг Засгийн газраас баталлаа. Монгол Улс төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийн зорилго нь төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцаа, хөрөнгийг хувьчлах замаар хувийн хэвшилд суурилсан эдийн засгийн тогтолцоог бүрдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулж, улмаар хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, хувьчлалаас орох орлогыг ашиглан тухайн компани, хуулийн этгээдийн техник, технологийг шинэчлэн сайжруулж, улс орны эдийн засгийн тогтвортой хөгжлийн суурийг бий болгоход оршиж байна.

Тус ажлын хүрээнд Төрийн өмчийн хорооны 2015 оны 594 тоот тогтоолын дагуу “Монгол Шуудан” ТӨХК-ийн нийт хувьцааны тоог 99,586,363 ширхэг байхаар тогтоож нийт хувьцааны 34 хувийг

Уул уурхай

Гацууртын төлөө “гараа өргөө”

ц.буян

Стратегийн ордын 10 хувийг Хөрөнгийн биржээр арилжаалах ёстой

Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох тухай асуудал УИХ дээр гурван ч он дамнан яригдлаа. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод бүртгэгдээд жилийн нүүр үзэх гэж буй тус ордод хөрөнгө оруулах асуудал бусад стратегийн төслүүдийн адил удаашралтай байгаа.

Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгон арилжихаар болж, 6.3 тэрбум төгрөгийн хувьцааг анхдагч зах зээл дээр арилжив.

Өмч хувьчлалыг ийнхүү Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд арилжиж буй нь дараах ач холбогдолтой юм.

Нэгдүгээрт, хөрөнгийн зах зээл бол хамгийн шударга, нээлттэй, ил тод зах зээл. Монголын хөрөнгийн биржид бүртгүүлсэн хувьцааг компаниуд үйл ажиллагааныхаа тайланг ил болгодог, хувьцаа эзэмшигчдийн хурлаа зохион байгуулдаг. Компанийн засаглалыг хэрэгжүүлж, дүрэм журмын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг.

Хоёрдугаарт, Анхдагч зах зээлийн арилжааны захиалгаар үнэт цаасны хуваарилалтыг жижиг хөрөнгө оруулагч нарт таагай нөхцөлтэйгээр зохион байгуулдаг нь иргэн бүр төрийн өмчит компанийн хувьчлалд орох бололцоог нээж өгч байгаа юм.

Гуравдугаарт, Хувьцаа эзэмшигч бүр төрийн өмчит хувьцааг компанид хяналт тавих боломж нээгдэнэ.

Дөрөвдүгээрт, Төрийн өмчит компанийн үнэлгээг бодитоор үнэлж, олон нийтэд санал болгож буй нь тухайн компанийн хувьцаа бодит үнэ гэдгийг харуулж байна.

Тавдугаарт, Хоёрдогч зах зээлийн арилжаа нэмэгдэж улмаар Монголын хөрөнгийн биржийн өдөр тутмын арилжаа нэмэгдэх, цаашлаад үүсмэл үнэт цаасны зах зээл хөгжихөд ихээхэн хувь нэмэр болох юм. ■

Стратегийн ач холбогдолтой орд гэж юу вэ, тэд монголын эдийн засагт ямар үүрэг гүйцэтгэдэг вэ. Хуульд тодорхойлсноор үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсвэл жилд ДНБ-ний таван хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадамжтай ордуудыг энэ ангилалд авч үзнэ. Эрдэнэт, Оюутолгойн эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг бүгд мэднэ. Гэвч өнөөдрийг хүртэл эдгээр ордууд огт биелүүлж байгаагүй нэг үүрэг бий юм. Ашигт ▶

▶ малтмалын тухай хуулийн 5.6 дугаар зүйлд “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээд нь хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр арилжина” хэмээн тодорхой заасан буй.

Арван жилийн өмнө хууль батлагдсанаас хойш өнөөдрийг хүртэл хэн ч дээрх зүйл заалтыг хэрэгжүүлэх тухай хэн ч хөндөж ярьсангүй. Хэн ч хэрэгжүүлэх талаар анхаарал хандуулж байсангүй. Тийм мөртлөө хөрөнгийн зах зээл хөгжүүлэе гэж уриалж, мөн хөгжихгүй байна гэж цаг үргэлж шүүмжилж ирсэн. Гацууртын алтны ордын хувьд ч мөн адил. Гурван ч удаа Засгийн газраас асуудлыг УИХ-д өргөн барихад төрийн эзэмшлийн хувь хэмжээ, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хувь гэсэн асуудлыг хөндөж байснаас бус, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хувьцаагаа хөрөнгийн биржээр арилжих тухай ямар нэг шийдвэрт хүрсэн тухай мэдээлэл огтоос дуулдаж байсангүй.

Тус ордын төрийн эзэмшлийн хувийг тогтоох асуудлыг хэлэлцүүлэхээр УИХ-д өнгөрсөн оны аравдугаар сарын 23-нд өргөн барьсан. Өргөн мэдүүлсэн төслийг чуулганаар хэлэлцэх эсэх тухай асуудлыг парламент өнгөрсөн сарын 24-нд хэлэлцээд “хэлэлцэх нь зүйтэй” гэх шийдвэрт хүрсэн нь гурав дахь удаагийн тохиолдол байлаа.

Энэ удаад Гацууртын ордын 34 хувийг төр эзэмшиж, түүнийг орлох ашигт малтмалын нөөц ашигласны татварыг гурван хувиар тогтоожээ. Анх өнгөрсөн оны хоёрдугаар сард төрийн эзэмшлийн хувь хэмжээг 20 хувиар тогтоон оруулж ирсэн ч иргэний хөдөлгөөнүүдийн эсэргүүцэлтэй тулгарч, жагсаал цуглаан өрнөж, улс төржилт хэтийдсэнээс асуудал хойшлогдсон. Мөн зургадугаар сард төрийн эзэмшлийн хувь хэмжээг

34 хувиар тогтоон оруулж ирсэн ч ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг 1.7 хувь байлгах хөрөнгө оруулагчийн нөхцлийг хүлээн зөвшөөрөөгүй. Ингээд хөрөнгө оруулагчтай ахин хэлэлцээрт орсны эцэст хүрсэн шийдэл нь одоогийн өргөн бариад байгаа УИХ-ын тогтоолын төсөл.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд тус ордыг 17.1 сая тонн төмрийн хүдэр, 50 мянган тонн алтны нөөцтэй гэж бүртгэсэн. Гэхдээ 27.6 сая тонн төмрийн хүдэр, 75.9 мянган тонн алтны нөөцтэй гэх албан бус тооцоо бий бөгөөд цаашид ч нөөц өсөх магадлалтай гэж буй. Хүдэр дэх алтны агуулга харьцангуй өндөр, дэд бүтэц сайн хөгжсөн нь давуу тал. Ордыг ашигласнаар эдийн засагт оруулах хувь нэмэр, үр ашгийн тооцоолол өргөн барьсан төсөл бүрт өөрчлөгдөж байсан. Сүүлийн тооцооллоор Монголын талын мөнгөн урсгал зах зээл дээрх алтны ханшаас хамаараад 339.8-490.7 сая ам.доллар (нийт дүнгийн 58-70 хувь) байна гэж таамаглаж буй. Жил бүр таван тонн алт олборлож Монголбанкинд тушаана, татварын орлогод 200 сая төгрөг төвлөрнө, 1000 орчим ажлын байр бий болох аж.

Эцэстээ анхны хувилбараасаа 60 сая ам.доллар л илүү олох боломжтой болж байгаа нь энэ. Ойролцоогоор нэг жилд олгодог хүүхдийн мөнгөний хагас нь. Гэтэл саарал ордон дотор мунгинаж өнгөрөөсөн хугацаанд Ноён ууланд юу өөрчлөгдөв.



Хууль бус алт олборлогч “нинжа” нар олноороо цуглаж, өдөр шөнөгүй ухаж сэндийлж байна. Хөвсгөл, Архангай, Дархан-Уул, Төв, Сэлэнгэ аймгаас 1800 орчим иргэн тус ордод хууль бусаар ашигт малтмал олборлох ажиллагаа явуулж байгаа аж. Хамгаалалтын алба ажиллаж байгаа ч хүч хүрэхгүй нөхцөл байдал бий болсон. Хууль бусаар алт олборлогч “нинжа” нар тэдний шаардлагыг биелүүлэхгүй эсэргүүцэж, мод, чулуугаар зэвсэглэн шөнийн цагаар дайрч довтлох болжээ. Ердийн үед 300-500 орчим иргэд 24 цагийн турш ажиллаж байгаа гэнэ.

Ноён уул гэмт хэргийн талбар болж архидалт, танхайрал газар авч, ухсан нүх шороо булаалдсанаас нэгнээ хутгалж гэмтээсэн тохиолдлууд удаа дараа гарах болжээ. Мандал суманд гэмт хэргийн тоо өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 20 хувиар нэмэгджээ. Тэдгээр иргэдийн дунд эрүүгийн гэмт хэрэгт холбогдож, удаа дараа ял шийтгэгдсэн нэр бүхий хэд хэдэн хүн нүх амуудыг хуваарилах нэрийдлээр бусдыг айлган сүрдүүлж дарамталдаг болоод байгаа аж.

Гэтэл энэ бүхэн нь үнэн хэрэгтээ ашиглана, ашиглуулахгүй гэж өөр зуураа зөрчилдөж байх зуурт бий болсон “Гацууртын аманд маш их алт байгаа” гэх төөрөгдлөөс үүдэлтэй. 20 жилийн тэртээгээс шороон ордыг “Гацуурт” компани олборлож 2002 онд дууссан. Сүүлийн жилд үндсэндээ хаягдал дахин боловсруулсан гэхээр өнөөдөр гараар малтаад 1800 хүн баяжчихаар их алт тэнд байхгүй нь тодорхой. Нэмэлт хайгуулаар илэрсэн 50 тонн нөөц нь ихээхэн хатуу чулуулгийн гүнд байгаа гэж буй.

“Гацуурт” төслийг зогсоох хүчтэй шалтгаан нь Ноён уул дахь түүхийн дурсгалууд. Алтны нөөц илэрсэн гэх Сүжигтэй нь Хүннүгийн үеийн булш, архелогийн олдворууд түгээмэл байдаг гурван амын нэг. Гэхдээ тэдгээр дурсгал нь ордоос 2.8-5


км зайтай аж. Түүнчлэн 20 жилийн өмнө ордыг ашиглаж, газар нь ухагдсан. “Сентерра гоулд” компани олборлолт хийснээр нөхөн сэргээлт хийх үүргийг өөртөө хүлээх юм. Мөн “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр болсон. Энэ нь Ноён уул орчмын байгаль орчны гэнцвэрт байдал, унаган төрхийг хадгалах, түүх соёлын үнэт өв болон амьтан, ургамал, газар нутгийг хамгаалах зорилготой.

Гурав дахь удаагаа өргөн барьсан тогтоолын төсөлд УИХ-ын гишүүдийн шаардлага хангагджээ гэж харж болохоор байна. Эдийн засаг мухардалд орсон энэ цаг үед мега төслүүдийн хөрөнгө оруулалтыг шийдэх нь их дэмтэй, олон эерэг өөрчлөлтийг араасаа дагуулах нь тодорхой. Тиймээс Гацууртын ордыг урагшлуулах саналыг гараа өргөн дэмжье. Гэхдээ нэг болзолтойгоор. Мартаад 10 жил болсон хуулийн заалтыг хэрэгжүүлж тусгай зөвшөөрөл эзэмшигчийг Монголын хөрөнгийн бирж дээр 10 хувийн хувьцаагаа арилжаалсан тохиолдолд. Хэрвээ үүнийг ажил хэрэг болговол Монгол Улсын иргэд Ноён уулаа ухалгүйгээр ордоос хууль ёсны дагуу бодитойгоор ашиг хүртэх боломжтой болно. Ноён уулаар улстөр хийгсэд ч мөн үнэний өмнө гараа өргөн бууж өг. ■



Монголын хөрөнгийн бирж нь өдөр тутмын арилжааны болон ханшийн мэдээллийг түгээх гар утасны мобайл аппликейшныг зах зээлд нэвтрүүлээ

Тус аппликейшн нь Монголын хөрөнгийн биржийн гишүүн үнэт цаасны компаниудын холбогдох хаяг, удирдлагын мэдээлэл, холбоо барих утас болон хаягийн мэдээллийг нэмж оруулсан бөгөөд мөн хувьцаат компаниудын үнэт цаасны ханшийн өөрчлөлтийг түүхэн графикаар харах боломжийг танд өгч байна. Цаашид уг аппликейшныг ашиглан гар утаснаасаа арилжаанд оролцох боломжийг хөрөнгө оруулагчдад хүргэхээр зэхэж байна.





“БидиСЕК ҮЦК” ХК


ТАНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЧ

БИД МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД 25 ДАХ ЖИЛДЭЭ АМЖИЛТТАЙ АЖИЛЛАЖ БАЙНА.

НИЙТ ГҮЙЛГЭЭНИЙ ХЭМЖЭЭ /БидиСЕК хийж гүйцэтгэв/



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ



ТАНД САНАЛ БОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭ:

- ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРЭЭС САНХҮҮЖИЛТ ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ
- ХУВЬЦАА АВАХАД ЗУУЧЛАХ
- ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД АВАХАД ЗУУЧЛАХ /ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ДИЛЕР/
- СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ
- ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХ
- ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ
- ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ
- ҮНЭТ ЦААСНЫ ДАНС НЭЭХ

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ, КОМПАНИЙН САЙН ЗАСАГЛАЛ ЗЭРГЭЭР ҮНЭЛГЭЭ ӨГДӨГ ОЛОН УЛСЫН “GLOBAL FINANCE” СЭТГҮҮЛЭЭС МАНАЙ КОМПАНИЙГ “BEST BROKERAGE” БОЛОН “BEST INVESTMENT BANKING” - ААР ТУС ТУС ӨРГӨМЖЛЭГДСЭН.



ХОЛБОО БАРИХ:

СБД 8-Р ХОРОО ЗАЛУУЧУУДЫН ӨРГӨН ЧӨЛӨӨ 27/1
УТАС: (976) 11313108; (976) 11323411 ЦАХИМ ШУУДАН: info@bdsec.mn
ЦАХИМ ХАЯГ: www.bdsec.mn

Ипотек

Хувьцаат компани болсноор засаглал зөв шугамд орлоо

Г.ОРХОН



Бидэнд Засгийн газрын хөтөлбөрт багтдаггүй, өөрөөр хэлбэл найман хувийн хүүтэй зээлээс дээш хүүтэй моргейжийн зээлийг худалдан авах сонирхол бий

Монголын санхүүгийн зах зээлд нэгэн шинэ салхи салхилуулж, компанийнхаа нийт хувьцааны 15 хувийг олон нийтэд нээлттэй арилжаалаад буй компани бол “МИК Холдинг” ХК. Тус компани нийт 17.6 сая ширхэг хувьцаатай бөгөөд нэмж 3.106.398 ширхэг хувьцааг нийтэд арилжаалаад байна. Монголын Хөрөнгийн биржийн нэгдүгээр ангилалд бүртгэгдсэн анхны хувьцаат компани болсон амжилтаар цан цохисон тус компанийн ТУЗ-ийн дарга М.Мөнхбаатартай ярилцлаа. Тэрбээр “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-д 2008 оноос хойш гишүүнээр, сүүлийн нэг жилд ТУЗ-ийн даргаар ажиллаж байна.

–“МИК Холдинг” ХК одоогийн байдлаар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах эрхтэй цорын ганц байгууллага болоод байна. Нээлттэй хувьцаат компани болсноор танай компанийн хувьд ямар өөрчлөлт бий болоод байна вэ?

–Нээлттэй хувьцаат компани болсон талаар ярихаас өмнө МИК гэдэг компанийн түүхийг ярих ёстой байх. “МИК Холдинг” компани Төвбанк болон

арилжааны 10 банкны санаачлагатайгаар 2006 онд байгуулагдсан. Ингэхдээ Монгол Улсад моргейжийн зах зээлийг хөгжүүлэх, цаашдаа олон улсад хэрэглэж буй санхүүгийн хэрэгслүүдийг улсдаа нэвтрүүлж иргэдийг орон сууцаар хангах зорилго өвөртөлсөн. Үүнээс хойш 2008 онд хөрөнгөөр баталгаажсан анхны үнэт цаасыг гаргасан юм. Харин 2013 он компанийн хувьд хөгжлийнхөө дараагийн шатанд орсон жил байлаа. Учир нь Төвбанк болон Засгийн газраас моргейжийн зээлийн хөтөлбөрийг 2013 оны зургадугаар сараас хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд бид анх 300 тэрбум төгрөгийн бондыг тухайн оны арванхоёрдугаар сард гаргасан бөгөөд энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ гаднын олон зөвлөх компанитай хамтарч ажилласан. Тухайлбал, Малайзын Үндэсний Ипотекийн Корпораци “CAGAMAS” компанийн гүйцэтгэх захирал байсан зөвлөх, Малайз, Сингапур, Хонконгийн зах зээлд зөвлөх үйлчилгээ үзүүлдэг хуулийн фирм зэрэг мэргэжлийн байгууллагуудын зөвлөмжтэйгээр улсдаа моргейжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулаад явж байна.

Өнгөрсөн онд компанийн ТУЗ хуралдан бидний үйл ажиллагаа нийгэм болон санхүүгийн зах зээлд хүлээсэн үүргээ тодорхой хэмжээгээр гүйцэтгэсэн гэж үзсэн. МИК нөлөө бүхий үйл ажиллагаатай компани болсон байна. Санхүүгийн хувьд тогтвортой болж, ашиг орлого нь ч баталгаатай боллоо. Тиймээс бид компанийн хүртэж буй ашгийг илүү олон хөрөнгө оруулагчид хүргэн засаглалаа улам сайжруулахаар зорьсон. Моргейжийн хөтөлбөрт хамрагдаж буй олон гэр бүлийн эрх ашиг манай компаниар дамжуулан хөндөгдөж байгаа учир компанийн засаглалыг сайжруулах тал дээр ажиллах нь зүйтэй гэх шийдвэр гаргасан. Олон улсад засаглалыг сайжруулахын тулд компани өөрөө нээлттэй болох ёстой гэж үздэг. Өмнө нь иргэд зөвхөн орон сууцтай болж, МИК-ийн ашиг орлогыг хүртэх боломжгүй байсан бол одоо хувьцаа эзэмшигч болсноор бий болж байгаа нийт баялгаас дивиденд ногдол ашгийг хүртэх боломж бий болгоё гэдэг зорилго тавин ажилласан. Ингээд манай хувьцаа эзэмшигчид болон зохицуулагч байгууллагууд бидний ажлыг ойлгож, дэмжсэн тул маш богино хугацаанд хувьцаа гаргаж, нээлттэй хувьцаат компани болох ажлыг хийлээ.

–Өнгөрсөн хугацаанд найман хувийн зээлийн хөтөлбөрт хамрагдсан 78 мянган иргэнээс 47 мянга гаруйнх нь зээл ипотекийн зээлээр баталгаажсан бонд буюу үнэт цаас болжээ. Энэ зээлийн санхүүжилтыг тогтворжуулах, сайжруулах ямар арга зам байна вэ?

–Таны дурьдсанчлан ийм олон өрхийг орон сууцтай болгохын тулд өнгөрсөн хугацаанд өөрийн хувь нэмрээ оруулсан байгууллагуудын нэг бол яах аргагүй МИК. Үүнд 200 тэрбум төгрөгийн үндсэн болон хүүгийн төлбөрийг оруулж байна. Цаашид энэхүү 200 тэрбум төгрөгөөр хүмүүс дахин орон сууцтай болох боломж бүрдэж байна гэсэн үг. Бидний харж байгаагаар энэ систем нь цаашид өргөжихөөр өөрөө өөрийгөө хангахуйц эргэлт бий болгоно. Энэ хэмжээний хөрөнгийн эргэн төлөлт явж байгаа учир тогтвортой үргэлжлэх боломж бүхий давуу тал бий болгож байна.

–Нээлттэй хувьцаат компани болсноор энэ эргэлтийг илүү дэмжиж өгсөн гэж ойлгож болох уу?

–Тийм ээ, нээлттэй компани болсноороо энэ үйл явцыг хууль эрх зүйн болон компанийн засаглалын хувьд зөв явуулах давуу тал үүсгээд байгаа ▶

► юм. МИК бүтцийн санхүүжилтийн инженерчлэл, зуучлал үзүүлдэг газар. Нэг талд нь бүтээгч хөрөнгө оруулагчид буюу компанийн хувьцаа эзэмшигчид байдаг. Нөгөө талд нь бонд эзэмшигч нар. Харин гуравдагч талд моргейжийн хөтөлбөрт хамрагдсан иргэд. Эдгээрийн ашиг сонирхлыг базаж, төвлөрүүлж байгаа газар нь МИК юм. Тэгэхээр МИК-ийн үйл ажиллагаа тогтвортой, засаглал сайтай байснаараа өөрийн хөрөнгийн хөшүүргээр өөрийгөө цаашаа аваад явах боломж бүрдүүлж байгаа юм.

-Та бүхний төлөвлөгөө олон нийтэд ил тод болсон. Улсаа хамгийн том IPO хийж, 37.3 тэрбум төгрөгийг хөрөнгийн зах зээлээс босгохоор төлөвлөөд байгаа.

-Өнгөрсөн арванхоёрдугаар сарын 24-нд анхдагч зах зээлийн арилжаа хийснийг хөрөнгийн зах зээлд оролцогч, сонирхогчид мэдэж байгаа байх аа. Манай компанийн андеррайтераар “ТиДиБи капитал “ҮЦК” ажилласан. Энэ компани маш сайн ажилласны үр дүнд бид хүссэн хэмжээний хөрөнгөө босгож чадлаа. МИК-ийн үйл ажиллагааны ойрын таван жилийн ажлын талаар мэдье гэвэл үнэт цаасны танилцуулгатай танилцаж болно. Үүн дээр үндэслэн хоёрдогч зах зээлийн арилжаанаас манай хувьцааг худалдан авах боломж бий. Компанийн үйл ажиллагаа тогтвортой, ил тод байгаа нь харагдана. Хоёрдогч зах зээлийн арилжаа өчигдрийн байдлаар /2016.01.12/ 12210 төгрөг болсон байна. Он гарснаас хойш 210 төгрөг буюу 1.8 орчим хувиар хувьцааны үнэлгээ өссөн гэсэн үг. Эндээс МИК-д итгэх итгэл иргэдийн дунд байгаа нь харагдаж байна. Мөн өнгөрсөн долоо хоногийн турш хамгийн их арилжаалагдсан хувьцаа байлаа. Хөрөнгийн биржийн А самбарын анхны компани болсондоо баяртай байгаа. Бид хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хүлээсэн үүргээ хариуцлагатай биелүүлэхийн тулд өөрсдийнхөө зүгээс төлөвлөсөн бүхнээ хийхийн төлөө ажиллана.

-Ипотекийн зээлээр баталгаажсан бонд дахин гаргана гэж байгаа. Энэ ажлын үр дүн иргэдэд хэрхэн тусах вэ?

-Энэ ажлыг бид байнга хийдэг. Хоёр их наяд төгрөгийн актив гэдэг нь актив талдаа бид моргейжийг худалдан авч байна. Пассив талдаа моргейжийн зээлийг багцлан түүгээр барьцаалсан үнэт цаас гаргадаг энэ процесс явдгаараа л явж байна. Бидэнд компанийн үйл ажиллагааг тэлэх үүднээс Засгийн газрын хөтөлбөрт багтдаггүй, өөрөөр хэлбэл найман хувийн хүүтэй зээлээс дээш хүүтэй моргейжийн

зээлийг худалдан авах сонирхол бий. Үүнд IPO хийж босгосон мөнгөө ашиглана гэсэн төлөвлөгөө байна.

-Ер нь ипотекийн зээлийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад “МИК Холдинг” ХК хэр өргөжсөн бэ?

-Моргейжийн хөтөлбөр манай компанийн үйл ажиллагааг нэлээд дэмжсэн. 2013 оноос хойш компанийн өөрийн хөрөнгө ес дахин нэмэгдсэн. Актив хөрөнгө өнгөрсөн оны арванхоёрдугаар сарын байдлаар хоёр их наяд төгрөгт хүрлээ. Энэ нь хөрөнгө оруулагчдын хувьд ашиг нэмэгдэнэ гэсэн үг. 2012 оноос хойш манай өсөлт ямархуу түвшинд хүрснийг энэ хоёр тооноос харж болно.

-Ипотекийн зээлийг үргэлжүүлэх шаардлагатай гэдэгт “МИК Холдинг” ХК-ийн байр суурь нэгддэг. Тэгвэл цаашид ямар алхмаар үргэлжүүлэх нь зөв шийдэл вэ?

-Бидний одоогийн сонгосон нь зөв зам гэж боддог. Моргейжийн хөтөлбөр нь төрөөс сүүлийн жилүүдэд хэрэгжүүлсэн эдийн засаг болон нийгмийн ач холбогдолтой томоохон төсөл хөтөлбөр болж чадсан. Эдийн засгийн ач холбогдолтой гэдэг нь шууд утгаараа иргэдийг орон сууцтай болгож, хуримтлал бий болгож байна. Өмнө нь хүмүүс мөнгөө цуглуулж байгаад байр худалдан авдаг байсан бол одоо урьдчилгаа төлбөр 30 хувиа төлөөд орон сууцны зээлд хамрагдан байртай болж байна. Мөн нийгмийн хувьд томоохон ач холбогдолтой. Орон гэртэй болсон

хүн эдийн засаг, санхүүгийн хувьд илүү хариуцлагатай болдог. Иргэд урьдчилгаа төлбөрөө төлөхийн тулд мөнгөө цуглуулдаг болж байна. Цалингаа аваад зээлийн төлбөрөө төлдөг болсноор тансаг хэрэглээнд гэхээс илүүтэй амьдралынхаа бодит хэрэгцээнд зарцуулж байна. Манай компани энэ зах зээлийн томоохон оролцогчийн нэг болчихлоо.

-Та манай улсын санхүүгийн салбарын хөгжлийг хэрхэн харж байна вэ?

-Манай санхүүгийн систем технологи талаасаа дэлхийд тэргүүлэгчдийн дунд орно. Монголд нэвтэрсэн интернэт банкны үйлчилгээ гэхэд Америкийн зарим нэг муж улсын арилжааны банкинд нэвтрээгүй байна. Гэхдээ санхүүгийн салбарын зарим нэг хэрэгсэл манайд хараахан нэвтрээгүй. Энэ нь санхүүгийн зах зээлд гэхээсээ илүүтэй ерөнхий эдийн засагт оролцож буй оролцогчдын оролцооны асуудлаас болж байгаа. Мэдээлэл дутмаг байх шиг. Нөгөө талаас энэ талаарх ойлголт дулимаг байна. Тэгэхээр эдийн засгийн нэг үе өнгөрөхөөр санхүүгийн бусад хэрэгслүүд орж ирэх байх. Ерөнхийдөө бид бусдаас нэг их хол хоцроогүй, хөл нийлүүлж яваа гэж бодож байна. “МИК Холдинг” ХК-ийн хувьд энэ бол эдийн засаг дахь шинэ үзэгдэл. Манай компани эдийн засагт болон санхүүгийн зах зээлд нөлөө үзүүлэхүйц компани болоод байна. Тиймээс тодорхой хэмжээний үүрэг хүлээн, хариуцлагаа биелүүлж явна. ■

Дэлхийн зах зээл

Давааны цаадах даваа

Б.ЭНХЦЭЦЭГ

Том шийдвэр дагасан том үр дагавар

АНУ-ын Холбооны Нөөцийн банк /ХБН/-наас шинэ жилийн бэлэг болгон бодлогын хүүгээ 0.25 хувиар оны өмнөхөн нэмлээ. 2006 оноос хойш огт хөдлөөгүй тус хүү ийнхүү хөдөлгөөнд орсон нь Америк хямралаас хойш хэр хэмжээнд “сэргэсний” мөн ХНБ “сэрсний” дохио байв.

Сүүлийн хоёр жил идэвхтэйгээр нэмнэ, нэмэхгүй хэмээн яригдсаар өдийг хүрч биеллээ олсон учир дээрх шийдвэр

“сюрприз” бол байгаагүй нь мэдээж. Дэлхийн хамгийн хүчирхэг эдийн засаг учир иймэрхүү тохируулга тус улсад байтугай дэлхий даяар зах зээлүүдэд эерэг сөрөг олон нөлөө авчирдаг. Энэ удаа “хэзээ нэмэх бол” хэмээх ажил уясан хүлээлтийг эцэслэсэн нь тус шийдвэрийн тааламжтай тал нь байв. АНУ-ын эдийн засаг дахин суга таяггүйгээр өөрөө алчихах чадалтай болсон хэмээн Төв-банк итгэж буйгаа илэрхийлсэн. Энэ жилийн хувьд хэд хэдэн удаа бодлоын хүүг үе шаттайгаар нэмэх хүлээлт байгаа бөгөөд дараагийн нь гуравдугаар сард гэх таамаг байна. ►

► Бодлогын хүү нэмэгдснийг дагаад АНУ болон Азийн хувьцааны зах зээлүүд өссөн дүнтэй хаалтаа хийсэн бол Европт голлох индексүүд нь гурван хувиар цойлсон эерэг үзүүлэлтэйгээр дээрх мэдээг утгсан билээ. Америк долларын хувьд мөн тус шийдвэрийг амдан чангарах шинж үзүүлж эхэлсэн нь хямд мөнгөн тэмдэгтийн мөчлөгт цэг тавигдсаныг харуулах мэт. Ийнхүү хувьцаанууд өсөх хандлагаар хариу барьсан нь тодорхой байдал тогтсонд талархсан хэрэг байв.

Хямралаас хойш АНУ-ын хөдөлмөрийн зах зээлд 12 сая ажлын байр шинээр бий болж ажилгүйдэл таван хувиар буурсан ба цалингийн өсөлт үзэлгүй өдийг хүрсэн ч саяхнаас нэмэгдэж эхэлсэн. Мөн Америкийн эдийн засгийн өсөлт цаашид тогтвортойгоор өсөх хандлагатай байгаа бөгөөд ХНБ өсөлтийн таамгаа өндөрсгөсөн. Энэ бол бодлогын хүү өсөх болсон шалтгаан. Хэрвээ тус улс тогтвортой өсөлтөө хадгалсаар байвал цаашид ч Төвбанк бодлогын хүүг энэ эрчээр нь өсгөнө.

Бодлогын хүү тухайлбал, хөрөнгө оруулагч, орон сууц худалдан авагч, хадгаламж эзэмшигчид гээд олон сая америкчуудад нөлөөлнө. Хадгаламж эзэмшигчид бага зэргийн хүүгийн унацтай байх бол том банкууд ямар ч өсөлт үзэхгүй нь. Харин моргейжийн зээлийн хүү аажмаар өснө. Үйлдвэрлэл болон эрчим хүчний салбарт тэр дундаа бусдаас илүү дарамт авчирхаар байгаа ч ХНБ-ны дарга Иеллен Женнет АНУ-ын эдийн засгийн эрүүл мэнд энэ зэргийг давахаар эрүүлжсэн гэж үзээд байна. Гэхдээ тэрбээр хөрөнгө оруулагчдад дараагийн бодлогын хүү өсгөх үйл явц эдийн засгийн сэргэлтийг “шороотой хутгачихааргүй” алгуур нямбай байна гэдгийг амласан билээ.

Америкийн томоохон банкуудын дуу хоолой хамгийн чанга байсан ба Сити групп, Америкийн банк, Гольдмэн Сааксын хувьцаа хоёр хувиар чангарсан. Банкууд зээлийн хүүгээ нэмэх боломж үүсч байгаа учраас тэд баяртай байгаа. Үүнтэй зэрэгцэн тэр даруй Жипи Морган тэргүүтэй банкууд зээлийн хүүгээ нэмж, хадгаламжийн хүүгээ хэвээр нь үлдээхээр төлөвлөж буйгаа зарласан.

Бондууд өндөр өгөөж хүртээх үү

АНУ-ын Засгийн газрын өрийн аюул багатай зах зээл ч мөн ХНБ-ны шийдвэрт хариу үйлдэл үзүүлж буй. Алдарт шийдвэрийн дараахан бондуудын жишиг хүү болох Америкийн 10 жилийн хугацаатай өрийн бичгийн өгөөж 2.27 хувиас 2.39 хувь болтлоо өссөн ба өнгөрсөн долоо хоногт мөн өсөлт үзүүлсэн. Гэвч оны хоёр дахь долоо хоногийн байдлаар өгөөж буурч, үнэ нэмэгдээд байна. Үүнийг шинжээчид Хятадын эдийн засгийн эрсдэлтэй байдалтай холбож байна. Харин Европт тухайлбал, Германы 10 жилийн хугацаатай бондын өгөөж 2.1 суурь нэгжээр өсч 0.539 хувь болоод байна. Асуудал огцом эргэчихгүй л бол бондууд ерөнхийдөө хөрөнгө оруулагчдад өндөр өгөөж өгөх төлөвтэй байна. Ам.доллараар зарсан богино хугацаатай бондуудын өгөөжид илүүтэй өөрчлөлт гарахаар байгаа юм. “Junk” бондын айдсын давааг газрын тосны үнийн навсайлт улам ч гүнзгийрүүлсэн. Таваарын зах зээлийг бондын зах зээлээс хасаад харвал, нөхцөл байдал арай дээр харагдана. Гэвч “Junk” бондын түгшүүр мөн эрсдэлтэй хөрөнгөд мөнгөө оруулсан сангуудаас үүдэн өндөрсөж буй. Өгөөж өндөрсөөд байвал эдгээр доогуур ангилалд орсон бондын эзэд илүү их өрөнд орж, хөрөнгө оруулагчид мөнгөө олж авч чадахгүй байхаас улам болгоомжилно.

Америк доллар хурдалсаар байх үү

2015 оны гайхам шийдвэрийн дараа Америк доллар нэг их хөдөлгөөнд ороогүй. Евро мөнгөн тэмдэгт 1.09 ам.доллартай тэнцэх болсон нь жилийн өмнөх 1.25 ам.доллартай харьцаж байснаа

бодвол огцом уналт. Гэхдээ яахав өнгөрсөн сард 1.06-тэй дүйж ирснийгээ бодвол ч энэ ханш гайгүйдээ орно. Харьцангуй бяд суугаад байгаа Америкийн эдийн засгийг бодлогын хүүгийн хүлээгдсэн буй цаашдын өсөлттэй хамтагтавал ам.доллар өрсөлдөгч мөнгөн тэмдэгтүүдийн эсрэг мэдэгдэхгүйц чангарахаар байгаа. Гэхдээ нэг асуулт байгаа нь бодлогын хүү дахиад өсөхөд ам.доллар дагаад хурдаа барих уу гэдэг байна.

Бодлогын хүүг “чулуун ёроолд” тулгасан нь сэргэлтийг өдөөсөн ч олон эдийн засагч үүнийг мөн санхүүгийн хөөс үүсгэх суурь болж өгсөн байхвий гэж эмээж буй. ХНБ зээл авахад хялбар бас хямд болгон зээлийн эрсдэлээс айх айдсыг үргээсний улмаас эдийн засаг “нокаутанд” орох магадлал өндөрссөн гэх. Гэхдээ мөн л үүнийг дагах асуулт нь аль салбар хамгийн мэдрэг байна вэ гэдэг юм.

Өнгөрсөн жил ч мөн шинжээчид хэлж байсанчлан ХНБ бондын зах зээлийн үйл ажиллагаанд зовнингуй харц шидэлж ирсэн. Энэхүү хэдэн их наяд ам.долларын зах зээлд корпорациудын өрөөс эхлүүлээд ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас хүртэлх олон өр багтана. Хүлээж байсанчлан хэт доогуур хүүнүүд нь Америк даяар нэлээн хэдэн салбарт мэдэгдэхүйц өрийн “өндрийг” нэмээд байна. Санхүүгийн хөөсийн хамгийн танил эх сурвалж бол хөрөнгийн зах зээл. Хямралаас хойш хувьцаанууд гайхмаар сайн илааршилт үзүүлсэн. S&P 500 индекс гэхэд 2008 оноос хойш хоёр дахин өссөн үзүүлэлттэй байгаа. Хөрөнгийн зах зээлүүд шинэ, шинэ өндөрлөгүүдэд гарах тусам хэтэрхий сайн сэргэлтийн үзүүлэлт, хувьцаануудын үнэлгээтэй болж буйд санаа зовох хүн олширч буй. Хувьцаанууд хэт дээгүүр үнэлэгдснийг гэрчлэх нэг хэмжүүр нь үнэ-орлогын харьцаа юм. Компанийн нэгж хувьцааны зах зээлийн үнийг нэгж хувьцаанд ногдох ашигт хувааж тооцдог. Одоогоор харьцаа 25 хувь байна. Энэ бол хөөсрөөд баларч байсан толгой эргэм үетэй харьцуулбал харьцангуй доогуур байгаа ч түүхэн хэмжээнүүдээс харахад ялт ч үгүй өндөр.

Хөрөнгө оруулагчдын хувьд одоогоос хоёр ►



► жилийн дараа ч гол хүүг хоёр хувиас доогуур хэвээр байна гэдэг хүлээлттэй байгаа. Хямрал зөгнөгчдийн зүгээс Америкийг тийм ч дархлаа сайтай болсон гэж итгэхгүй байна. “Wall Street Journal” сэтгүүлийн санал хураалтад оролцсон 65 эдийн засагчийн ихэнх нь ХНБ ирэх таван жилийн дотор тэг хувийн бодлогын хүү рүү эргээд ухарна гэж үзжээ. Энэ бол үндсэндээ Америкийг дахиад хямарна гэж бодож байгаагийн илрэл юм. ■

Сурвалжлага

Томрох хүсэл

Б.ЭНХ

Бондыг даатгах болсон нь дотоодын санхүүгийн салбарт шинэ үзэгдэл болж буй. Үүнээс гадна даатгалын байгууллага хөрөнгө оруулалтын сангийн эх үүсвэрийг бүрдүүлдэг уялдаа холбоо бүхий санхүүгийн үйл ажиллагаа ороод ирлээ.

Богоно хугацааны зовлонг давж, урт хугацааны хөгжлийг харахыг 600 гаруй оролцогчоосоо хүсэж, хамтдаа зүтгэхийг уриалсан нь “Санхүүгийн зах зээлийн хөгжил Үндэсний форум-2016”-г зохион байгуулагчдын хувьд эдийн засаг хүндэрсэн энэ үед хийсэн хэт өдрөг бас зоригтой оролдлого байв.

“Зах зээл удааширч аль ч салбар бэрхшээлтэй тулгарч, банкуудын чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдснээр даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ ихэсч буй ийм байдалд энэ форум зохиогдож байна” хэмээн Монголын банкны холбооны ерөнхийлөгч О.Орхон тус форумыг тодорхойлон хэлсэн.

Монгол Улсын санхүүгийн салбар өрсөлдөх чадвараар 140 орноос 104 дүгээрт эрэмблэгдэж зургаан байраар ухарсан үзүүлэлттэй байгаа. Энэхүү үзүүлэлтийг тус салбар банкнаас хэт хамааралтай хөгжсөн ба үнэт цаас, даатгал бичил санхүүгийн салбарын өрсөлдөх чадвар сул байгаа гэх тайлбар гадагд.

УИХ-ын дарга З.Энхболд “Өдгөө дотоодын нийт бүтээгдэхүүний ердөө 4.7 хувийг санхүүгийн салбар эзэлж байна. Үүнээс дөрвөн хувийг банк, 0.7 хувийг



банкнаас бусад санхүүгийн салбар эзэлж байгаа нь тус салбарын гүнзгийрэлт олон улсын жишгээр хангалтгүй байгааг харуулж байна” гэв.

Нийт санхүүгийн салбарын дийлэнх хувийг эзэлж байна гэж шүүмжлэлд өртөж байдаг банкны салбар өдгөө үнэт цаас, даатгалын салбартай зарим үйл ажиллагааныхаа хувьд уялдаад явж байна. Банкны тухай хууль 2010 онд шинэчлэгдэн найруулснаас хойш банкны бүтээгдэхүүн нь даатгалын шинэ бүтээгдэхүүн тухайлбал, цалингийн даатгал, цалингийн зээлийн даатгал орон сууцны зээлийн даатгал болон хөгжиж байна. Мөн кастадион банкны үйлчилгээг зарим нэр бүхий банкууд үнэт цаасны зах зээлийнхэнд үзүүлж буй.

О.Орхон “Банк даатгалынхны хамтын ажиллагаа, даатгалын салбарын хөгжил энэ хоёр салбарыг салгаж үзэх нь өрөөсгөл гэдгийг харуулж буй. Эдийн засаг хүндэрсэн энэ үед тус хоёр салбар ялгаагүй хүндээр өртөж байна” хэмээв.

Сүүлийн хоёр жил гаруй хугацаанд телевиз, хэвлэлээр эдийн засгийн хүндрэлийг илтгэх чанаргүй зээлийн өсөлт, гадаад өрийн цойлолт, ДНБ-ий бууралт, уул уурхайн бүтээгдэхүүний үнийн уналт гэх мэт муу мэдээ чих дэлсэх нь давамгайлсан. Монголын эдийн засгийн өсөлт л гэхэд 2015 оны урьдчилсан гүйцэтгэлээр 2.5 хувь болж саарсан гэдгийг МУ-ын сайд, ЗГХЭГ-ын дарга С.Баярцогт тус чуулганы үеэр хэлсэн.

Дэлхийн банкны судалгаагаар, манай орны 15-аас дээш насны иргэдийн 75 хувь санхүүгийн байгууллагад данстай байгаа аж. Мөн насанд хүрсэн бүх хүн мобайл банкны үйлчилгээ авах боломж бүрдсэн. Нэг хүнд ногдох санхүүгийн

байгууллага болон АТМ машины тоогоор хөгжилтэй орнуудын хэмжээнд хүрсэн гэж үнэлэгдэж. Ингээд нийт дүр зургаар нь харвал, санхүүгийн хүртээмжийн үзүүлэлтээр өндөр хөгжилтэй орны тоонд орж байна. Зөвхөн уламжлалт зээл, төлбөр тооцоо, хадгаламжаар хязгаарлагдахгүйгээр бүх төрлийн активийг удирддаг, хөрөнгө оруулалтын сан, үнэт цаасны багцын менежмент хийдэг олон үйлчилгээ нэвтэрч байгаа.

Харин энэ олон хэрэгцээ шаардлагыг цаг хугацаанд нь мэдэрч, зохицуулах нь сорилт болоод байгааг СЗХ-ны дарга З.Нарантуяа онцолсон. Тэрбээр мөн “Цаашид олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зохицуулалтыг хэрэгжүүлэх нь хөрөнгө оруулагчдын итгэлийг олоход илүү туслах учиртай” гэв.

Хэдий санхүүгийн зах зээлд тодорхой хурдтайгаар хөгжиж байгаа ч урт хугацааны хөрөнгө оруулалт, хуримтлалын хэмжээ бага, эх үүсвэрийн өртөг өндөр мөн хадгаламж, даатгалын талаарх иргэдийн мэдлэг тааруу хэвээр. Санхүүгийн салбарын гүйцэтгэдэг үүргийг илэрхийлдэг гол үзүүлэлт салбарын гүнзгийрүүлэлт буюу ДНБ-д эзлэх салбарын хэмжээ доогуур байсаар. Харин нөгөө талаас дэлхийн санхүүгийн зах зээлийн зохицуулах байгууллагууд зах зээлээ мэдэрч удирдах, оролцогч бүрт тохирсон зохицуулалтыг хийх арга барил руу шилжиж байгаа. Техникийн шинэ шийдлүүд дээр суурилсан шинэ санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хөөн гүйцэж зохицуулахад амаргүй болгож байгаа. Мөн үүнтэй зэрэгцээд технологийн хөгжил нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, үсрэнгүй хөгжлийг бий болгож байгаа юм. ►

▶ Хөгжил рүү санхүүгийн салбараар “газарчлуулах нь”

УИХ-ын намрын чуулганаар Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг баталсан. Монголын эдийн засаг өдгөө цөөн хэдэн салбараас хамааралтай. Энэхүү тэнцвэргүй байдлыг арилган олон салбарт тулгуурласан тогтвортой хөгжлийн замаар замнах нь хөгжлийн хөтөлбөрийн эрхэм зорилт. Үр ашигтай шударга өрсөлдөөнт орчныг бүрдүүлэхэд чиглэсэн салбарын хууль мөн дунд хугацааны хөтөлбөрийг батласнаар санхүүгийн зах зээл илүү тогтвортой хөгжих боломж нэмэгдэнэ гэж бодлого тодорхойлогчид тунхаглаж буй.

“Нийтийн ашиг сонирхолд тулгуурласан бизнесийн компаниуд нээлттэй компанийн хэлбэрт шилжих илүү таатай нөхцлийг бүрдүүлэх, татварын бодлогыг оновчтой болгох, үнэт цаасны зах зээлийн бүтээгдэхүүний чанарыг сайжруулах тал дээр хийх ажил их” хэмээн УИХ-ын дарга З.Энхболд онцолсон.

Санхүүгийн хүртээмжийг үнэлдэг үзүүлэлтээр шинэ технологи дээр суурилж үйлчилгээг авч чадаж буй тоогоор манай улс өндөр байгаа ч үйлчилгээний дараа хэр бодитой үр шимийг хүртэж байна вэ гэдгийг харвал хангалтгүй байгаа.

Нийт биржид бүртгэлтэй компаниудын цөөн хэдийнх нь үнэт цаас идэвхтэй арилжаалагддаг мөн мэдээллийн хаалттай байдал нь үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагчдыг идэвхгүй байдалд оруулдаг гол шалтгаан байсаар байна гэж Жайка зөвлөх багийн Такаюки Урадэ илтгэлдээ онцолсон юм.

“Хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаа улс орны эдийн засагт урт хугацааны хөрөнгийг бий болгодог гэдэг утгаар илүү анхаарал тавьж шинэ механизмуудаар дэмжсэн байдлаар бодлогын бичиг баримтаа боловсруулсан” хэмээн СЗХ-ны дарга З.Нарантуяа хэлсэн.

“Хөрөнгийн бирж энэ жил өөрийгөө зохицуулах байгууллага болсон. Тиймээс дүрэм журмаа шинэчлээд үнэт цаас гаргахад 90 хоног зарцуулдаг байсныг 30 хоног болгож, зардлыг 60 хувиар багасгасан байна” хэмээн МХБ-ийн Маркетинг, олон нийтгүй харилцах албаны дарга Ж.Мягмарсүрэн хэллээ.

Жилдээ 1-2 компани анхдагч зах зээлээр дамжуулан хувьцаагаа арилждаг /ПРО хийдэг/ байсан бол 2015 онд дөрвөн

компани ПРО хийжээ. Хөрөнгийн бирж дээр ганц хувьцаа гэдэг бүтээгдэхүүн арилждаг байсан бол хувьцаа, компанийн бонд, Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаас, арилжаалж байна.

Бондыг даатгах болсон нь дотоодын санхүүгийн салбарт шинэ үзэгдэл болж буй. Үүнээс гадна даатгалын байгууллага хөрөнгө оруулалтын сангийн эх үүсвэрийг бүрдүүлдэг уялдаа холбоо бүхий санхүүгийн үйл ажиллагаа ороод ирлээ. Энэ бүхэнд эрсдэлээс сэргийлсэн зохистой зохицуулалт хийх шаардлага бий. Үүнийг оролцогчид мөн ихээхэн сонирхож байлаа.

Санхүүгийн хөгжлийн тухай чуулган Улаанбаатар хот санхүүгийн төв болох тухай алсын зорилгоор цэгээ тавьсан. Оролцогчдын зүгээс энэхүү санхүүгийн

төв болох зорилгыг ойрын асуудлуудаас гараагүй энэ нөхцөлд билэгшээхээс хэтрэхгүй байсан ч, боломжгүй зүйл бол биш гэдэгт санал нэгдэж байв. Магадгүй энэ мэт холын зорилгыг тавьж том зургаар харж ажиллахгүй аваас ойрын зовлон оршоод ч байгаа юм бил үү.

Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк зэрэг байгууллагууд зохицуулалтуудын хязгаарыг суллаж, боломжуудыг нээгээд өгөх юм бол асар их чадавхи энэ салбарт байгааг зөвхөн моргейжээр дамжуулан зах зээл хэр хурдацтай өссөнөөс харж болно гэдгийг оролцогчдын зүгээс онцолсон. Олон компани энэ зах зээлийн хүрээнд өсөх, томрох хүсэлтэй байна. Хувь, хувьсгалын аль аль нь салбарын чуулганы үеэр үгээ хэлж, саналаа тодорхойллоо. ■

Шинэ нөхцөл

г.мөнх-эрдэнэ

“Монгол шуудан” компанид шинэ нөхцөл байдал үүсээд байна. 100 хувь төрийн өмчит компани байсан өнгөрсөн оны арванхоёрдугаар сарын 28-наас энэ оны нэгдүгээр сарын 06-ны хооронд 34 хувиа хөрөнгийн зах дээр арилжаалж нээлттэй компани болсон бол тус компанийн хувьцааны хоёрдогч зах зээл удахгүй нээгдэхээр боллоо.

Анхдагч зах зээл дээр хувьцаа худалдан авах захиалга нийлүүлэлтээс зуун хувь илүү байлаа. Энэ нь хоёрдогч зах зээлд хувьцааны ханш өсөх магадлалыг нэмэгдүүлж байгаа юм. Учир нь анхдагч зах зээлд нийт эрэлтийн 50 хувь нь л хангагдсан гэсэн үг.

1. Дотоодын институциональ хөрөнгө оруулагч орж ирлээ. Энэ нь “Ард Санхүүгийн Нэгдэл” юм.

Андеррайтерийн компанийн зүгээс 10,000 ширхэгээс бага худалдан авах захиалга өгсөн бүх хөрөнгө оруулагчдын хувьцааг тэргүүн ээлжинд 100 хувь нийлүүлж, үлдсэн хувьцааг том хөрөнгө оруулагчдад хувь тэнцүүлэн тараасан. Ингэснээр ХҮРТЭЭМЖТЭЙ мөн ТЭГШ хувьчлалыг хийж чадлаа.

Шинэ орчин


6.2 тэрбум төгрөг босгосноор ажил дуусч байгаа хэрэг биш ээ. Харин ч эсрэгээрээ ажил эхэлж байна. Хөрөнгө

оруулагч бүр ашгийн төлөө явж байгаа. Тэгэхээр урт, дунд, богино хугацаанд ханш өсөх үү? унах уу? гэдгийг тодорхойлох ёстой гэсэн үг.

Богино хугацаанд суурь бус хүчин зүйлээс хамаарч ханш өсөх тохиолдол бий. Жишээ нь, анхдагч зах зээлд эрэлтийн хэмжээ нийлүүлэлтээс зуун хувь илүү байвал хоёрдогч захад ханш өсөх тохиолдол бий.

Харин дунд ба урт хугацаанд яах вэ?

Дунд ба урт хугацаанд компанийн суурь үзүүлэлт сайжирснаар хувьцааны ▶



▶ ханш өснө. Суурь үзүүлэлт гэдгийг компанийн орлого, ашиг, мөнгөн урсгалын өсөлт гээд ерөнхийд нь ойлгочихож болно. Тэгвэл эдгээр үзүүлэлтүүд ямар хүчин зүйлээс хамаарч өөрчлөгдөх вэ? Хүчин зүйлсийг эх сурвалжаар нь гадаад ба дотоод хүчин зүйлс гэж ангилдаг. Жишээ нь, макро эдийн засгийн уналт нь компанийн орлого ашгийг бууруулж хувьцааны ханшид сөргөөр нөлөөлнө. Энэ бол гадаад хүчин зүйлс. Гадаад хүчин зүйлсийг компани өөрөө удирдах боломжгүй бөгөөд зөвхөн урьдчилан таамаглал хийж эрсдэлээ тооцох замаар нөлөөллийн хүчийг судруулж чадна.

Харин дотоод хүчин зүйл гэж юу вэ? Олон хүчин зүйл байгаагаас тус компанийн хувьд “хувьцаа эзэмшигчдийн нэгдмэл байдал” маш их анхаарал татаж байна.

Монгол Шуудан ХК-ийн хувьд 34 хувийг хувьчлан авсан хөрөнгө оруулагчид нэгдэн хамтран ажиллах, мөн төрийн 66 хувьтайгаа гар нийлэн ажиллах шаардлага үүсч байна. Энэхүү хамтран ажиллах эв зохицол бүрэлдсэнээр компани дунд ба урт хугацаандаа тогтвортой тасралтгүй ажиллаж үүний хэрээр санхүүгийн гүйцэтгэл нь сайжрах юм.

Иймээс жижиг хөрөнгө оруулагчид энэхүү зохицол хэрхэн бүрэлдэхийг анхааралтай ажиглаж мэдээлэлтэй байх шаардлагатай.

Удахгүй “Хувьцаа эзэмшигчдийн хурал” болох бөгөөд одоогийн ТУЗ нь шинэчлэгдсэн. Шинэчлэгдсэн ТУЗ нь зөв бүрэлдсэн цагт ажил цаашаа явна. Хуулийн дагуу ТУЗ-ийн гишүүдийн 1/3-ээс багагүй нь хараат бус гишүүн байх ёстой бөгөөд эдгээр гишүүд нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад голлох үүрэг гүйцэтгэх учиртай.

Энэ бүх мэдээллийг авахын тулд “Хувьцаа эзэмшигчдийн хурал”-даа заавал суу. ТУЗ-ийн нарийн бичгийн даргаас хуулинд олгогдсон эрхийнхээ дагуу мэдээллээ сайтар ав. Брокерийн компаниаа нягт холбоотой бай. ■

Хувьцаа эзэмшигчдийн хуралд заавал суух 4 шалтгаан

1 ҮНЭН БОДИТ МЭДЭЭЛЭЛ:

Анхдагч эх сурвалжууд болох компанийн удирдлагуудаас үнэн бодит мэдээллийг ямар ч дамжуулагчгүйгээр шууд авах боломжтой

2 БҮРЭН ГҮЙЦЭД МЭДЭЭЛЭЛ:

Компанийн шийдвэр гаргах түвшний хүмүүсээс хуссан асуултаа асууж, бүрэн гүйцэд мэдээлэл авах боломжтой.



4 ДҮГНЭЛТ ХИЙХ БОЛОМЖ:

Хуралдаанаар өнгөрсөн жилийн төлөвлөгөө, үр дүн, ирэх жилийн төлөвлөгөөг танилцуулдаг. Ингэснээр компанийн үйл ажиллагаанд бодит дүгнэлт хийж, төлөвлөгөөнд үндэслэн ханшийн таамаг хийх боломжтой

3 ХЭМНЭЛТ:

Монголын нөхцөлд үнэн бодит, бүрэн гүйцэд мэдээлэл цуглуулахад маш их цаг хугацаа, зардал шаарддаг. Хуралд оролцсоноор та цаг хугацаа, зардлаа хэмнэх боломжтой.

Компанийн тухай хуулиас

98 дугаар зүйл. Компанийн талаар мэдээлэл авах

98.1. Хувьцаат компани нь

- Жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан,

- Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо болон

- Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын дүрэм, журмаар тогтоосон бусад мэдээллийг өөрийн үнэт цаас эзэмшигчийн хүсэлтээр танилцуулах үүрэгтэй.

98.2. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, компанийн гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал, шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглоноос

- Бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөртэй хуулбарлан авах бололцоог хувьцаа эзэмшигчид олгох үүрэг хүлээнэ.

98.3. Хувьцаат компанийн энгийн хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн аль нэг хувьцаа эзэмшигч нь

- Компанийн энгийн хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийннэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, түүний эзэмшлийн хувьцааны тоо зэргийг агуулсан бүртгэлийг шаардан гаргуулах эрхтэй.

98.4. Компанийн гүйцэтгэх удирдлага, эсхүл хувьцаа эзэмшигчдийн бүртгэл хөтлөх эрх бүхий байгууллага энэ хуулийн 98.3-т заасан шаардлагыг хүлээн

авснаас хойш ажлын таван өдрийн дотор шаардлага гаргасан өдрөөр тасалбар болгон бүртгэлийг гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд үүнтэй холбогдон гарах зардлыг шаардлага тавьсан этгээд хариуцна.

98.5. Энэ хуулийн 98.1-98.2, 98.4-т заасан үүргээ биелүүлээгүй эрх бүхий албан тушаалтанд энэ хуулийн 85.4-т заасан хариуцлага хүлээлгэнэ.

100 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

100.1.1. хувьцаат компани энэ хуульд заасан тайлан тэнцэл, мэдээ, мэдээллийг нь нийтэд болон эрх бүхий байгууллага, хувьцаа эзэмшигчид танилцуулах, мэдээлэх, тайлагнах, мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол тухайн компанийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, холбогдох эрх бүхий албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох;

100.1.2. энэ хуулийн 6.4, 32.5, 39.4, 40.3, 48.1, 49.2, 49.6, 49.14, 51.2, 63.10, 66.9, 67.2, 69.3, 73.1, 84.3, 94.2, 94.15, 97.1, 97.5, 97.6, 98.2-т заасныг зөрчсөн бол хувьцаат компанийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос гуч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, холбогдох эрх бүхий албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох ■